Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 дугаар тушаалын
1 дүгээр хавсралт

# ОРХОН АЙМГИЙН БҮСИЙН ОНОШИЛГОО ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН 2025-2029 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

2025 ОН

# АГУУЛГА


НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Оршил
1.2 Үндэслэл

ХОЁР. МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ

ГУРАВ. ГАДААД, ДОТООД ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ
3.1. Гадаад орчны шинжилгээ
3.2. Дотоод орчны шинжилгээ

ДӨРӨВ. БҮСИЙН ОНОШИЛГОО ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН АЛСЫН ХАРАА, ЭРХЭМ ЗОРИЛГО, БАРИМТЛАХ ЗАРЧИМ, ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ
4.1. Алсын хараа
4.2. Эрхэм зорилго
4.3. Баримтлах зарчим
4.4. Тэргүүлэх чиглэл
4.5. Хэрэгжүүлэх хугацаа

ТАВ. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО, ЧИГЛЭЛ БА ЗОРИЛТУУД
5.1 Байгууллагын үйл ажиллагааны хөгжлийг дэмжих,удирдлага зохион байгуулалтыг боловсронгуй болгох
5.2 Эмнэлгийн тусламж үйлчилгээ
5.3 Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ
5.4 Хүний нөөцийн хөгжил
5.5 Мэдээллийн технологи, мэдээллийн удирдлага
5.6 Эмнэлгийн хагас бие даасан байдал, санхүүгийн тогтвортой байдлыг хангах стратеги
5.7 БОЭТ-ийн дэд бүтцийн хөгжил

ЗУРГАА. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО БА САЛБАР, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН БҮТЦИЙН УЯЛДАА, ЗУРАГЛАЛ

ДОЛОО. СТРАТЕГИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ХҮРЭХ ТҮВШИН

НАЙМ. СТРАТЕГИЙН ХЯНАЛТ ҮНЭЛГЭЭ

ЕС. СТРАТЕГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

АРАВ. ХАВСРАЛТУУД

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ЭМЯ-Эрүүл мэндийн яам

ЭМХТ- Эрүүл мэндийн хөгжлийн төв

ЭХЭМҮТ-Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв

ЗДТГ- Засаг даргын тамгын газар

ЭМГ-Эрүүл мэндийн газар

БОЭТ-Бүсийн оношилгоо эмчилгээний төв

СЭМТ-Сумын эрүүл мэндийн төв

ӨЭМТ-Өрхийн эрүүл мэндийн төв

ХХЭМБ-Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага

ЭМБ-Эрүүл мэндийн байгууллага

ЭХНБ-Эм ханган нийлүүлэх байгууллага

ЭМС-Эрүүл мэндийн салбар

ААНБ- Аж ахуй нэгж байгууллага

БТСГ- Биеийн тамир спортын газар

НДХ-Нийгмийн даатгалын хэлтэс

НЭМ-Нийгмийн эрүүл мэнд

НҮЭМ-Нөхөн үржихүйн эрүүл мэнд

ОУБ- Олон улсын байгууллага

ОБГ- Онцгой байдлын газар

ТБ-Төрийн байгууллага

ТББ-Төрийн бус байгууллага

УЗХ-Улаан загалмайн хороо

ХЭАН-Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг

# НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

## 1.1. Оршил

Бүсийн оношилгоо эмчилгээний төв (цаашид “БОЭТ” гэх)-ийн үйл ажиллагааны стратеги нь Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн захирал (цаашид “захирал” гэх)-ын Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд чиглэгдсэн эмнэлгийн болон нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, тусламж үйлчилгээг чанар хүртээмжтэй зохион байгуулах, оношилгоо эмчилгээнд шинэ дэвшилтэт технологи нэвтрүүлэх, нутагшуулах, эмчилгээ оношилгооны хожимдол үүсгэхгүй байх, бүс нутгийн эрүүл мэндийн байгууллагуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэх, мэргэжил аргазүйгээр хангах, өөрийн үйл ажиллагаандаа хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийх, үр дүнд нь үнэлгээ дүгнэлт гаргах, бодлого боловсруулах, лавлагаа шатлал руу чиглэх урсгалыг бууруулах, иргэд орон нутагтаа лавлагаа шатлалын тусламж үйлчилгээнд цаг алдалгүй хамрагдах, байгууллагын хөрөнгө оруулалт, санхүүжилтийг оновчтой төлөвлөх, хүний нөөцийг хөгжүүлэх, чадавхжуулах, тэдгээрийн нийгмийн баталгааг хангах, эрүүл салбарын цахим шинэчлэлтийг байгууллагын үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлэх, дэд бүтцийг үе шаттай хөгжүүлэх зэрэг асуудлуудыг хамарсан үйл ажиллагааны стратегийг тодорхойлоход чиглэгдсэн.

Энэхүү стратеги төлөвлөгөө нь Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 2025-2029 онд баримтлах дунд хугацааны хөгжлийн стратегийн үндсэн баримт бичиг болно.

## 1.2. Стратеги төлөвлөгөөний үндэслэл

Орхон аймаг нь Монгол улсын хэмжээнд нэг хавтгай дөрвөлжин километр нутаг дэвсгэрт ногдох хүн амын нягтралаараа Улаанбаатар хотын дараа ордог. Эрдэнэт хот анх байгуулагдахад 1655 өрхийн 7.8 мянган хүн амтай байсан бол 2024 оны байдлаар 30.3 өрх,109.800 хүн амтай, хүн амын жилийн дундаж өсөлт 2,2 хувь, хүн ам зүйн ачаалал 57.9, үүнээс хүүхэд 38.2, дундаж наслалт 73.34, /эрэгтэй 72.32, эмэгтэй 86.1/ байна. Аймгийн хүн амын 57 хувь нь хөдөлмөрийн нас, 10.2 хувь нь 60-аас дээш насных бөгөөд эдийн засгийн идэвхтэй хүн амын 95,2 хувь нь хөдөлмөр эрхэлж, нийт иргэдийн 53 орчим хувь нь орчин үеийн тохилог орон сууцанд амьдарч байна.

Хүн амын өвчлөлийн тэргүүлэх шалтгаанд 2024 оны байдлаар хоол боловсруулах тогтолцооны өвчлөл 1392, амьсгалын тогтолцооны өвчлөл 10000 хүн амд 1371, шээс бэлгэсийн тогтолцооны өвчлөл 715.6, цусны эргэлтийн тогтолцооны өвчлөл 615.7 промиллоор тэргүүлж байна. Амьсгалын замын өвчлөлд цочмог амьсгуурстас, гүйлсэн булчирхайн үрэвсэл, амьсгалын дээд замын цочмог халдвар зонхилж байна. Зонхилон тохиолдож буй цусны эргэлтийн эрхтэн тогтолцооны өвчлөлд зүрхний ишемит өвчнүүд, артерийн даралт ихсэлт, тархины судасны өвчнүүд, зүрхний хэм алдагдалт зэрэг нь нийт өвчлөлийн 70 хувийг эзэлж байна.

Аймгийн хэмжээнд 2024 онд шинээр 324 хорт хавдрын өвчлөл бүртгэгдэж 10000 хүн амд 30.8 промилл, 191 нас баралт бүртгэгдэж өмнөх оны мөн үеэс 68 тохиолдлоор өссөн. Хорт хавдрын өвчлөлд элэг, ходоод, уушги, улаан хоолойн хавдрууд тэргүүлж байна. 2024 онд шинээр бүртгэгдсэн хавдар: 1.Элэг-78 буюу 24.1% 2.Ходоод-68 буюу 21.0% 3.Уушги-26 буюу 8.0% 4.Улаан хоолой 21 буюу 6.5% 5.Хөх 17 буюу 5.2% 6.Бөөр 15 буюу 4.6% 7.Умай 14 буюу 4.3% 8.Нойр булчирхай 10 буюу 3.1% тус тус оношлогдсон байна.

2024 онд нас баралтын 525 тохиолдол бүртгэгдэж 1000 хүн амд ногдох нас баралтын ерөнхий коэффициент 5.0. Өмнөх оноос 38 тохиолдол 0.4 промиллоор өссөн. Нийт нас баралтын 214 буюу 40.8 хувь нь эмэгтэй, 311 буюу 59.2 хувийг эрэгтэйчүүд

ээлж байна. Нийт нас баралтын 35.4%-ийг зүрх судас, 31.2%-ийг хорт хавдар, 6.5%-ийг осол гэмтэл гадны шалтгаант нас баралт ээлж байна

Бүсийн оношилгоо эмчилгээний төв нь Нэгдсэн эмнэлгийн MNS 6330:2017 стандартыг хэрэгжүүлж ажилладаг ба ЭМДЕГ-тай 419 оношийн хамааралтай бүлгээр гэрээлж нэн шаардлагатай тусламж, үйлчилгээг бүрэн үзүүлэх, шаардлагагүй хэвтэлт, үр ашиггүй тусламж, үйлчилгээг бууруулах, төвлөрлийг сааруулах, иргэдийг санхүүгийн эрсдэлээс хамгаалах зорилго тавин 2024 онд 23,683.8 мянган төгрөгний батлагдсан урсгал зардлын төсөвтэй удирдах болон гүйцэтгэх, үйлчлэх 524 ажиллагсадтай эмнэлгийн тусламж үйлчилгээний үндсэн үйл ажиллагаа тасралтгүй явагдахад шаардагдах хөрөнгийн зарцуулалтыг төрийн сангийн удирдлагын цахим системээр болон санхүүгийн интерактив цогц програмд бүртгэн, эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны 6-р тогтоолын хэрэгжилтийг хангаж 8 алба, 26 тасаг нэгж, 32 үзлэгийн кабинет, 433 эмнэлгийн ортойгоор эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлэн ажиллалаа.

Хүний нөөцийн өнөөгийн байдал




Төсөв, санхүүжилтийн төлөв байдал




| | 2022 он | 2023 он | 2023 он | 2024 он |
|---|---|---|---|---|
| ЭМД-н санхүүжилт | 21,825,826.00 | 23,017,691.60 | 19,032,890.00 | 28,590,653.96 |
| Үйл ажиллагааны орлого | 660,452.80 | 679,371.50 | 785,186.40 | 854,180.48 |
| Орон нутаг | 445,199 | 391,861.60 | 424,500 | 1,339,450 |
| Дээд шат | 720,385.80 | 15,692 | 1,442,155 | 1,197,641 |
| Нийт дүн | 23,651,863.60 | 24,104,616.70 | 21,684,731.50 | 31,981,926.00 |

ЭМД-н санхүүжилт · Үйл ажиллагааны орлого · Орон нутаг · Дээд шат · Нийт дүн

## Эрүүл мэндийн статистик үзүүлэлтүүд

/2023, 2024 оны жилийн эцсийн байдлаар/

| № | Үзүүлэлт | Нэгж | Улсын дүн | 2023 он | 2024 он | Өсөлт бууралт |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Төрсөн эх | Бодит тоо | 63915 | 2227 | 2004 | -223 |
| 2 | Амьд төрсөн хүүхэд | Бодит тоо | 64308 | 2231 | 2016 | -215 |
| 3 | Амьгүй төрсөн хүүхэд | Бодит тоо | 344 | 9 | 8 | +1 |
| | | 1000 нийт төрөлтөд | 5.3 | 4.0 | 3.9 | +0.1 |
| 4 | Эхийн эндэгдэл | Бодит тоо | 17 | | | |
| | | 100 000 амьд төрөлтөд | 26.4 | | | |
| 5 | 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл /0-4 нас 364 хоног/ | Бодит тоо | 961 | 15 | 19 | +4 |
| | | 1000 амьд төрөлтөд | 14.9 | 6.7 | 9.4 | +2,7 |
| 6 | Үүнээс: Нялхсын эндэгдэл /0-364 хоног/ | Бодит тоо | 13 | 13 | 18 | +5 |
| | | 1000 амьд төрөлтөд | 5.8 | 5.8 | 8.9 | 3,1 |
| | Үүнээс: Нярайн эндэгдэл /0-28 хоног/ | 11 | 496 | 11 | 15 | +4 |
| | | 4.9 | 7.7 | 4.9 | 7.4 | +2,5 |
| | | 84.6 | 62.5 | 84.6 | 100 | +15,4 |
| | Нярайн эрт үеийн эндэгдэл /0-6 хоног/ | 8 | 326 | 8 | 15 | +7 |
| | | 72.7 | 65.7 | 72.7 | | |
| | Нярайн хожуу үеийн эндэгдэл /7-28 хоног/ | 3 | 170 | 3 | | |
| | | 27.2 | 34.3 | 27.2 | | |
| 7 | Перинаталь эндэгдэл | Бодит тоо | 670 | 17 | 23 | +6 |
| | | 1000 нийт төрөлтөд | 10.4 | 7.6 | 11.4 | +3,8 |
| 8 | Нийт нас баралт | Бодит тоо | 17533 | 487 | 525 | +38 |
| 9 | Эмнэлгийн нас баралт | Бодит тоо | 5537 | 105 | 125 | +20 |
| | | Хувь | 31.6 | 21.5 | 23.8 | +2,3 |
| 10 | Эмнэлэгт хоног болоогүй нас баралт | Бодит тоо | 1295 | 36 | 43 | 7 |
| | | Хувь | 23.4 | 34.2 | 34.4 | +0,2 |
| 11 | Эмчлэгдсэн хүний тоо | Бодит тоо | 1042835 | 17773 | 15906 | -1867 |
| 12 | Ор хоног | Бодит тоо | 71466999 | 120010 | 108327 | -11683 |

БОЭТөвд 2024 онд 2004 эх төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 223 тохиолдлоор буурсан. Төрсөн эхчүүдийн 1588 нь буюу 79,2 хувь нь эмчийн хяналтын үзлэгт 6 ба түүнээс дээш удаа хамрагдсан байгаа нь урд оноос 18,5-оор нэмэгдсэн байна. Нийт төрөлтийн 0.09 хувь буюу 2 тохиолдол нь гэрийн төрөлт байна. 2024 оны жилийн эцсийн байдлаар 596 тохиолдол буюу 29,7 хувь мэс заслын аргаар төрсөн нь өнгөрсөн оноос 3,1 хувиар нэмэгдсэн. Кесар хагалгаагаар төрсөн эхчүүдийн 86 буюу 14.4 нь анхны төрөлт, үүнээс 41 тохиолдол нь 15-25 хүртэлх насны эмэгтэйчүүд байна. Төрсөн эжүүдийн 33,0 хувь нь жирэмсэн үеийн, 28,7 хувь нь төрөх үеийн, 1,4 хувь төрсний дараах үеийн хүндрэлтэй төрсөн байна.



| | 2023 он | 2023 он | Зөрүү |
|---|---|---|---|
| Нийт төрөлт | 2227 | 2004 | -223 |
| Төрөлтийн түвшин | 18.0 | 16.2 | -1.8 |
| Амьгүй төрөлт | 9 | 8 | +1 |
| Амьгүй төрөлтийн түвшин | 4.0 | 3.9 | +0.1 |
| Гэрийн төрөлт | 6 | 2 | +4 |

БОЭТөвд 2024 оны жилийн эцсийн байдлаар 2016 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 215 тохиолдлоор буурсан бөгөөд төрөлтийн түвшин 1000 хүн амд 16.1 байна. Амьд төрсөн хүүхдийн 1011 буюу 50.1 хувь нь хүү, 49.9 хувь нь охин байна. Амьд төрсөн хүүхдийн 104 буюу 5.1 нь 2500 граммаас доош жинтэй, дутуу төрөлтийн түвшин 1000 амьд төрөлтөнд 62.5 буюу 126 тохиолдол байна. Төрсний дараа 1 цагийн дотор хөхөө амласан хүүхдийн эзлэх хувь 99.2 төрөлхийн гажиг 18 тохиолдолд бүртгэгдсэн нь нийт төрөлтийн 0.9 хувь байна. Амьгүй төрөлтийн түвшин 1000 нийт төрөлтөнд 3.9 байна.

Ойролцоо хүн ам, бусад БОЭТ-ийн төрөлт болон нас баралт

| | Нийт хүн ам | Төрсөн эх | Амьгүй төрсөн | Эхийн эндэгдэл | Нялхасын эндэгдэл | Нас баралт | Эмнэлгийн нас баралт | Хоног болоогүй нас баралт |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Ховд | 91457 | 1680-1691 | 11 | | 11-6.5 | 354 | 63 | 10 |
| Орхон | 110440 | 2005-2017 | 8 | | 20-9.9 | 525 | 127 | 44 |
| Өвөрхангай | 114630 | 1713-1720 | 4 | 1 | 22-12.8 | 574 | 107 | 23 |
| Хөвсгөл | 136845 | 1898-1902 | 10 | | 34-17.9 | 815 | 156 | 56 |
| Дархан | 109236 | 1809-1817 | 7 | | 12-6.6 | 515 | 214 | 66 |
| Өмнөговь | 75198 | 1190-1198 | 3 | | 21-17.5 | 339 | 81 | 38 |
| Дорнод | 84053 | 1343-1356 | 3 | 1 | 8-5.9 | 425 | 104 | 26 |
| УБ | 1.734.848 | 31120-31420 | 184 | 7 | 389-12.4 | 9174 | 3838 | 645 |
| Аймгуудын дүн | | 26199-26336 | 106 | 6 | 313-11.9 | 8939 | 1945 | 625 |

Амбулаторийн нийт үзлэг өнгөрсөн оны мөн үеэс 17883-аар нэмэгдсэн, нийт үзлэгт урьдчилан сэргийлэх үзлэгийн хувь 15.6 хувь байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 0.1-ээр нэмэгдсэн. Нийт 196723 үзлэг хийгдсэний 65.5 хувь нь эмэгтэйчүүд, 14.7 хувь нь 0-14 насны хүүхэд, 13.8 хувь нь харьяаллын бус хүмүүс үйлчлүүлсэн байна. Өвчний бүртгэл нийт үзлэгийн 31.7 хувьд онош тавьж бүртгэсэн нь өнгөрсөн онуудаас өссөн. Хүн амын өвчлөлийн бүтцийг харахад хоол шингээх, цусны эргэлт, нүд, чих хамар хоолойн, амьсгал, бөөр шээсний замын, арьс харшлийн өвчлөлүүд тэргүүлэх байранд байна. Амбулаторит бүртгэгдсэн нийт өвчлөл 56007 шинэ өвчин-28369, хуучин-2763




### Хэвтэн эмчлүүлэгсдийн тусламж үйлчилгээ

2024 оны жилийн эцсийн байдлаар 15906 үйлчлүүлэгч эмнэлэгт хэвтэн эмчлүүлж, 108327 ор хоног ашигласан байна. Энэ нь өнгөрсөн оны мөн үеэс хэвтэж эмчлүүлсэн нь 315 тохиолдлоор буурсан 19.7 хувийг /3136/ харьяаллын бус үйлчлэх хүрээний иргэд эзэлж байна. Эмнэлгийн нэг оронд хэвтэн эмчлүүлсэн өвчтөний тоо буюу **орны эргэлт** 36.7 /2023-42.2, улсын дүн 35.6/. Нэг өвчтөнийг эмнэлэгт хэвтүүлэн эмчилсэн **дундаж ор хоног**ийн тоо 6.8 /2023-6.7/. Нэг орыг ашигласан дундаж хоногийн тоо

**Орны фонд ашиглалтын хувь** 73.8 /2023-83.7, улсын дүн 65.6 аймгийн дүн 64.0/




### Стациоанарын өвчлөлийн тэргүүлэх шалтгаан



## Мэс заслын тусламж үйлчилгээ




## Түргэн тусламжийн дуудлага




## Нас баралт

БОЭТ-ийн нийт нас баралт 125, нийт тохиолдлын 43 тохиолдол буюу 34.4 хувь нь эмнэлэгт ирээд хоног болоогүй нас баралт, үүний 22 тохиолдол нь нь 8-24 цагийн дотор нас барсан байна. Нас баралтын 55.2 хувь нь эрэгтэй, 44.8 хувь нь эмэгтэй байна. Аймгийн нас баралтын тохиолдлын 23.8 хувь нь эмнэлэгт нас барсан, хоног болоогүй нас баралт өмнөх оны мөн үетэй ижил байна. Нас баралтын 14.4 хувийг нэг хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, осол гэмтэл, гадны шалтгаант нас баралтын 21 тохиолдол бүртгэгдэж, нийт нас баралтын 16.8 хувийг эзэлж байна.

Аймгийн нас баралт- Эмнэлгийн нас баралт-Хоног болоогүй нас баралт хувиар




Бүсийн оношилгоо эмчилгээний төв нь 2021-2024 оны байгууллагын стратеги төлөвлөгөөг батлуулж биелэлтийг удирдлагын зөвлөлийн 2024 оны 24дүгээр хурлаар хэлэлцүүлж ЭМЯ-нд 439 тоотоор хүргүүлсэн. Өөрийн үнэлгээ- 93.4%, ЭМЯ-ны үнэлгээ- 81.3 %.

**Хүрсэн үр дүн:**

1. Үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн хэрэгцээ шаардлагад нийцсэн эмнэлгийн тусламж үйлчилгээг чанартай, хүртээмжтэй хүргэх зорилтын хүрээнд зүрх судас, гэмтэл согог засал, бүдүүн, шулуун гэдэс, бөөр шээсний замын өвчлөлийн үеийн тусламж үйлчилгээнд дэвшилтэт технологи нэвтрүүлсэн
2. Хавдрын бай эмчилгээг орон нутагт амжилттай эхлүүлсэн.
3. Дурангийн мэс заслын тусламж үйлчилгээг өргөжүүлсэн. /Мухар олгой, бүдүүн, шулуун гэдэс , ERCP-1, цавины ивэрхий , уушги, эмэгтэйчүүд , шээлгүүрийн чулуу авах , урологи , цөсний хүүдий /
4. Ходоодны салст хуулах мэс засал, тархины цус харвалтын үеийн бүлэн хайлуулах эмчилгээ, судсан дотуурх оношилгоо, эмчилгээ, нярайн сурфактант эмчилгээ зэрэг шинэ дэвшилтэт технологийг нэвтрүүлэн нутагшуулж иргэн даатгуулагчийг орон нутагтаа төрөлжсөн нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээ авах нөхцлийг бүрдүүлж Улаанбаатар хот руу явах урсгал, төвлөрлийг бууруулан ажилласан.
5. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хангалтыг 95%-д хүргэсэн
6. Эрүүл мэндийг дэмжих төвийг байгуулж иргэдийг эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэгт тогтмол хамрагдах, хяналтад авах, эмчлэн эрүүлжүүлэх нөхцлийг бүрдүүлсэн.

Сүүлийн жилүүдэд хүн амын өсөлт, шилжилт хөдөлгөөнтэй холбоотойгоор Орхон аймгийн хүн амын тоо жилээс жилд нэмэгдэж, иргэдийн эмнэлгийн болон нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах хэрэгцээ ихэссэн, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого Алсын хараа 2050, Монгол улсын хөгжлийн таван жилийн үндсэн чиглэл, Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Орхон аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Орхон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан эрүүл мэндийн салбарыг үе шаттай хөгжүүлэх бодлого, арга хэмжээ хэрэгжүүлэх үндсэн хэрэгцээ шаардлагыг тус тус үндэслэн байгууллагын дүрмээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлэх, байгууллагын хөгжлийг хангах, иргэдийн эрүүл мэндийн хэрэгцээ шаардлагад бүрэн нийцсэн тусламж үйлчилгээг

шуурхай, чанартай, хүртээмжтэй, тасралтгүй хүргэх үйл ажиллагааг боловсронгуй болгох зорилго, зорилт дэвшүүлэн энэхүү стратегийг боловсруулլаа.

## ХОЁР. МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ

**Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн үүрэг:**

Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн үндсэн чиг, үйл ажиллагаа нь дараах хууль тогтоомжоор зохицуулагдана. Үүнд:

- Монгол Улсын Үндсэн Хууль
- Төрийн албаны тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ, худалдан авах тухай хууль
- Татварын ерөнхий хууль
- Нийгмийн даатгалын ерөнхий хууль
- Эрүүл мэндийн тухай хууль;
- Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль;
- Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль;
- Эрүүл мэндийн даатгалын тухай хууль;
- Хөдөлмөрийн тухай хууль ;
- Бусад холбогдох хууль, тогтоомж
- Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого;
- Монгол Улсыг 2025-2029 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл;
- Монгол Улсын Засгийн газрын 2025-2029 оны үйл ажиллагааны хөтөлбөр;
- Монгол Улсын Засгийн газрын 2001 оны 194-р тогтоолын 2-р хавсралт Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн дүрэм
- Монгол Улсын Засгийн газрын 2008 оны “Орхон аймагт Бүсийн оношилгоо, эмчилгээний төв байгуулах тухай” 56 дугаар тогтоол

<table>
<tr><td colspan="2">Салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хуулийн тоо</td><td>29</td></tr>
<tr><td rowspan="2">Үүнээс</td><td>Тухайн салбарын хуулийн тоо</td><td>11</td></tr>
<tr><td>Нийтлэг мөрддөг хуулийн тоо</td><td>18</td></tr>
<tr><td colspan="3">Ерөнхий чиг үүрэг-1 1. Бүс нутгийн хүн амын эрүүл мэндийн байдал, тусламж үйлчилгээний эрэлт хэрэгцээг судлах, мэргэжил аргазүйгээр хангах, судалгаа шинжилгээний ажил эрхлэх</td></tr>
<tr><td colspan="3">Үндсэн чиг үүрэг: Байгууллагын үйл ажиллагааны хөгжлийг дэмжих,удирдлага зохион байгуулалтыг боловсронгуй болгох</td></tr>
<tr><td>Үндсэн чиг үүрэг</td><td>Дэд чиг үүрэг</td><td>Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид</td></tr>
<tr><td rowspan="2">ҮЧҮ-1.1: Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд чанарын стандартыг нэвтрүүлэхийн зэрэгцээ чанар сайжруулах арга хэрэгслийг үйл ажиллагаандаа тасралтгүй ашиглах тогтолцоог бэхжүүлнэ.</td><td>Чанарын ISO 9001-2015 стандартыг нэвтрүүлэх</td><td rowspan="2">ЭМХТ, АЗДТГ, ЭМГ</td></tr>
<tr><td>Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах хөтөлбөр батлуулж хэрэгжилтийг хангаж ажиллана.</td></tr>
<tr><td>ҮЧҮ-1.2: Халдварын сэргийлэлт хяналтын тогтолцоог бэхжүүлж ЭТҮХХ-ын эрсдлийг бууруулж</td><td>Халдварын сэргийлэлт, хяналтад бичил амь судлалын лабораторийн гүйцэтгэх үүргийг өргөжүүлж чанаржуулах төлөвлөгөө боловсруулж</td><td>ЭМЯ, АЗДТГ,ЭМГ</td></tr>
</table>

| | | |
|---|---|---|
| ажиллана. | хэрэгжилтийг хангаж ажиллана<br>Нянгийн эсрэг эмийн хэрэглээг төлөвшүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ<br>ЭТҮХХ-аас сэргийлэх арга хэмжээний тогтолцоог бэхжүүлж нэн шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, халдваргүйтгэл ариутгалын бодис, угаалга цэвэрлэгээний тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлж чанарыг сайжруулна. | |
| **ҮЧҮ-1.3:** Эмнэлгийн тусламж үйлчилгээнд нэн шаардлагатай тоног төхөөрөмж, эм эмнэлгийн хэрэгслээр тасралтгүй хангана. | Эрчимт эмчилгээ мэдээгүйжүүлэг, эмгэг судлал, пренатал оношилгоо, мэс заслын тусламж үйлчилгээний чиглэлээр нэн шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана | ЭМЯ, ЭМХТ, АЗДТГ, ЭМГ, Донор байгууллагууд |
| **ҮЧҮ-1.4:** Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага MNS 7014:2023 стандартын хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллана. | Үйлчлүүлэгчийг дэмжих алба болон орон тооны бус зөвлөл, нэгжийг томилон ажиллуулна<br>Байгууллагын болон тасаг нэгжүүдийн гадна хаягжилт, эмнэлгийн гадна талбайн маршрут, орох гарах, гарц чиглэл, эмнэлгийн эдэлбэр газарт байгууламж хоорондын бүх явган хүний зам, тээврийн хэрэгслийн замын мэдээлэл, яаралтай тусламжийн тасгийн байршил заасан тэмдэг, яаралтай тусламжийн автомашины тэмдэглэгээ зэргийг стандартад нийцүүлэн зохион байгуулна<br>Эмнэлгийн амбулаторийн үзлэг, шинжилгээний дугаар авах, цаг товлох үйлчилгээ, дотоод хаягжилт, хэвтүүлэн эмчлэх болон өдрийн эмчилгээний өрөөнд дуудагдах дуудлагын тогтолцоог стандартад нийцүүлэн зохион байгуулна. | ЭМХТ, АЗДТГ, ЭМГ |
| **ҮЧҮ-1.5:** Бүс нутгийн түвшинд хүн амын эрүүл мэндийн эрэлт хэрэгцээг судалж эрдэм шинжилгээ судалгааны ажил зохион байгуулах, шинжлэх ухааны өгүүлэл, ном товхимол гаргах, төр, хувийн хэвшлийн түншлэлийг сайжруулах | Хүн амын өвчлөл нас баралтын тэргүүлэх шалтгаанд нөлөөлж буй хүчин зүйлс, халдварт бус өвчний тархалт, эрсдэлт хүчин зүйлс, түүнийг бууруулах арга замын талаар эрдэм шинжилгээ судалгааны ажлыг хийж үр дүнг практикт нэвтрүүлэх | АЗДТГ, ЭМГ |
| **Ерөнхий чиг үүрэг-2:** 2. **Эмнэлгийн тусламж үйлчилгээний стратеги :** | | |
| **Үндсэн чиг үүрэг:** Үйлчлэх хүрээний болон харьяалах нутаг дэвсгэрийн хүн амд эмнэлгийн тусламж үйлчилгээг чанартай хүртээмжтэй хүргэх, эмчилгээ оношилгоонд шинэ дэвшилтэт технологи нэвтрүүлэх нутагшуулах, хамтын ажиллагааг өргөжүүлж мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллах | | |
| **ҮЧҮ-2.1:** Бүсийн түвшинд Хавдрын оношилгоо эмчилгээ, хяналт–сэргийлэлт, Яаралтай тусламж, Пренатал | Төвүүдийн тусламж үйлчилгээ үзүүлэх эрхзүйн орчныг бүрдүүлэх бодлогын бичиг баримтыг боловсруулах | ЭМЯ, ЭМХТ, АЗДТГ, ЭМГ, Төрөлжсөн эмнэлгүүд |

| | | |
|---|---|---|
| оношилгоо, Зүрхний төвүүдийг байгуулж үйл ажиллагааг жигдрүүлнэ. | Хүний нөөцийг сургаж бэлтгэх | |
| | Тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлэх | |
| | Тусламж үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлж ЭМДЕГ –тай гэрээ байгуулах | |
| | Төвүүдийн тусламж үйлчилгээний чиглэл тус бүрээр хамтын ажиллагааг өргөжүүлэх | |
| **ҮЧҮ-2.2:** Мэс заслын тусламж үйлчилгээг өргөжүүлж хөгжүүлнэ | Хавдрын мэс заслын дэвшилтэт технологийг нэвтрүүлж нутагшуулна. (Элэг цөс, нойр булчирхай, ходоод, хөх) | ЭМЯ, ЭМХТ, АЗДТГ, ЭМГ |
| | Тархины бүх төрлийн хавдар, тархины судасны цүлхэнд хавчаар тавих, мөчдийн бүх төрлийн судас, мэдрэл шөрмөс залгах, шилжүүлэн суулгах, хүзүү нуруу нугасны мэдрэлийн дарагдал чөлөөлөх мэс заслуудыг нэвтрүүлэн нутагшуулна. | |
| **ҮЧҮ-2.3:** Орон нутагт эмчлэх, оношлох боломжгүй тусламж үйлчилгээг нутагшуулж шинэ дэвшилтэт технологийг нэвтрүүлнэ. | Зүрхний хэм алдагдлын электрофизиологийн оношилгоо, эмчилгээг нэвтрүүлж нутагшуулна. (Аблаци эмчилгээ) | ЭМЯ, ЭМХТ, АЗДТГ, ЭМГ |
| | Тархины судасны цүлхэн, эмгэг сүлжээрлийг судсан дотуурх бичил койлоор бөглөх аргыг нэвтрүүлж нутагшуулна | |
| | Хэвлийн дурангаар бөөр авах, давсагны хавдар авах мэс засал, бөөр тайрах мэс засал, нарийн гэдсээр хиймэл давсаг хийх мэс засал эмчилгээг нэвтрүүлж нутагшуулна | |
| | Хорт хавдрын оношилгоонд хавдрын генийн идэвхжил тодорхойлох (CISH) шинжилгээг нэвтрүүлж, хөхний хавдрын HER2 генийн олшрол, уушгины хавдрын EGFR генийн олшролыг илрүүлэх эдийн эрлийзжүүлгийн шинжилгээг хийнэ | |
| | Хэвлийн дурангаар умайг бүхэлд нь аарцгийн тунгалгийн булчирхайн хамт авах өргөтгөсөн хагалгааг нэвтрүүлж нутагшуулна. | |
| **Ерөнхий чиг үүрэг-3:** Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний стратеги | | |
| **Үндсэн чиг үүрэг:** Гамшгийн болон нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэх | | |
| ҮЧҮ- 3.1: Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж чанарыг сайжруулж, зорилтот бүлгийн иргэдийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд тогтмол хамрагдах нөхцөлийг сайжруулж, нийгмийн эрүүл мэндийн тусламж | Нийгмийн эрүүл мэндийг дэмжих орон тооны бус алба, нэгжийг байгуулна. | ЭМЯ, ЭМХТ, АЗДТГ, ЭМГ |
| | Зорилтот бүлгийн иргэн бүрийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд тогтмол хамрагдах тогтолцоог бэхжүүлнэ | |

| | | |
|---|---|---|
| үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, дэмжих бодлогыг хэрэгжүүлнэ | Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, гамшиг, онцгой байдлын үед урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэх чадавхыг бэхжүүлнэ. | |
| **Ерөнхий чиг үүрэг -4 :** Хүний нөөцийн хөгжлийн стратеги | | |
| **Үндсэн чиг үүрэг:** Эрүүл мэндийн ажилтны ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх боломжийг нэмэгдүүлж, нийгмийн баталгааг сайжруулан, тэдний эрүүл аюулгүй тав тухтай ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлэх | | |
| **ҮЧҮ-4.1:** Эрүүл мэндийн ажилтны ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх боломжийг нэмэгдүүлж, нийгмийн баталгаар сайжруулан, тэдний эрүүл аюулгүй тав тухтай ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлэх | Байгууллагын хүний нөөцийг хөгжүүлэх дэд хөтөлбөр батлуулж хэрэгжүүлж ажиллах | ЭМЯ, ЭМХТ, АЗДТГ, ЭМГ |
| | Эмнэлгийн мэргэжилтнийг үндсэн болон төрөлжсөн сургалтад хамруулж мэргэшүүлэх, чадавхжуулах | |
| | Эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн болон боловсролын зэрэг дэвийг ахиулах арга хэмжээг дэмжин зохион байгуулах | |
| | Эмнэлгийн мэргэжилтний баримтлах ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлэх ажлыг зохион байгуулах | |
| | Эрүүл мэндийн ажилтны нийгмийн баталгааг сайжруулан, урамшууллын тогтолцоог боловсронгуй болгох, тэдний эрүүл аюулгүй тав тухтай ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлэх | |
| | Төгсөлтийн дараах сургалт эрхлэх байгууллагын үйл ажиллагааг өргөжүүлэх | |
| **Ерөнхий чиг үүрэг -5 :** Мэдээллийн технологийн хөгжлийн стратеги | | |
| **Үндсэн чиг үүрэг:** Эрүүл мэндийн салбарт хийгдэж буй цахим шинэчлэлтийг байгууллагын үйл ажиллагаанд тухай бүр нэвтрүүлж сүлжээ, сервер, программын цахим аюулгүй байдлыг хангах, хөгжүүлэх технологийн шинэчлэл хийх | | |
| **ҮЧҮ-5.1:** Эрүүл мэндийн салбарт хийгдэж буй цахим шинэчлэлтийг байгууллагын үйл ажиллагаанд тухай бүр нэвтрүүлж сүлжээ, сервер, программын цахим аюулгүй байдлыг хангах, хөгжүүлэх технологийн шинэчлэл хийх | Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээнд хамрагдаж зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах | ЭМЯ, ТЕГ |
| | Байгууллагын дотоод сүлжээ, серверийн хүчин чадлыг сайжруулж интернэтийн хурдыг нэмэгдүүлэх, комьпютерийн хангалтыг нэмэгдүүлэх | ЭМЯ, АДЗТГ, ЭМГ, Юнитель групп |
| **Ерөнхий чиг үүрэг-6:** Байгууллагын дэд бүтцийг хөгжүүлэх стратеги | | |
| **Үндсэн чиг үүрэг:** Ажлын байрны болон үйлчлүүлэгчийн эрүүл аюулгүй орчин нөхцлийг бүрдүүлэх | | |
| **ҮЧҮ-6.1:** Байгууллагын барилга байгууламж, дэд бүтцийг хөгжүүлж сайжруулан стандарт, чанарын шаардлага хангасан үйлчилгээ үзүүлэх орчныг бүрдүүлнэ. | Шаардлагатай тасаг нэгжүүдэд дээврийн болон барилга их засвар хийх, агааржуулалтын шугам хоолойг шинэчлэх, суурилуулах гадна инженерийн шугам сүлжээ, цахилгаан кабель шугамыг шинэчлэх | ЭМЯ, АДЗТГ, ЭМГ |
| | Эмгэг судлал, Төрөх тасаг, Халдварт, сүрьеэ сэтгэцийн тасгуудад их засварыг үе шаттай зохион байгуулах | |

Бүсийн оношилгоо эмчилгээний төв нь хууль тогтоомжоор олгогдсон үндсэн чиг үүрэг, түүнд нийцүүлэн тодорхойлсон эрхэм зорилгоо хангахад чиглэгдсэн 2025-2029 онуудад баримтлах стратегийн зорилтыг дэвшүүлж байна. Байгууллагын стратегийн зорилтыг тодорхойлохдоо Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаатай уялдуулсан болно.

1. Байгууллагын үйл ажиллагааны хөгжлийг дэмжих,удирдлага зохион байгуулалтыг боловсронгуй болгох стратеги
2. Эмнэлгийн тусламж үйлчилгээний стратеги
3. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний стратеги
4. Хүний нөөцийн хөгжлийн стратеги
5. Мэдээллийн технологийн хөгжлийн стратеги
6. Байгууллагын дэд бүтцийг хөгжүүлэх стратеги

## ГУРАВ. ДОТООД ГАДААД ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

Гадаад орчны шинжилгээ

| Боломж | Бэрхшээл |
|---|---|
| **Засгийн газрын бодлого чиглэл, хууль эрх зүйн зохицуулалт** | |
| - Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичигт гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийг эрүүл мэндийн байгууллагад нэвтрүүлэх талаарх зорилтууд тусгагдсанаар эмнэлэг хагас бие даасан үйл ажиллагаа явуулах эрхзүйн орчин бүрдсэн<br>- Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолууд батлагдаж хэрэгжүүлж эхэлсэн<br>- Нийгмийн эрүүл мэндийн тухай анхдагч хуультай болсон | - Гүйцэтгэлийн санхүүжилтийн зарчмыг нэвтрүүлэхэд мөрдөгдөх журам зааврууд нь богино хугацаанд шинэчлэгдэх, шинээр хэрэгжих арга аргачлалд нөхцөл байдлаас шалтгаалж өөрчлөлт орох, эмнэлзүйн практикт нийцэхгүй байх зэрэг хүндрэлүүд нь тодорхой хүндрэлийг учруулж байна.<br>- Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилтийн шийдвэр гаргаагүй.<br>- ЭМДаатгалын санд төвлөрүүлэх санхүүжилт бага. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагыг гэрээнд заасан оношийн хамаарал бүлгээр хязгаарлаж тусламж үйлчилгээний нэр төрөл, хүртээмжийг хумих хандлагатай<br>- Оношийн хамаарал бүлгийг жил тутам шинэчлэх үйл ажиллагаа удаашралтай, хүний нөөц, тоног төхөөрөмжийг гэрээлэх нөхцөлөөр эмнэлгийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх заалт хэрэгждэггүй<br>- Гүйцэтгэх удирдлагад санхүүгийн эрх мэдлийг бүрэн шилжүүлээгүй<br>- Инфляцийн өсөлт, олон улсын харилцаа, тээвэр ложистикийн тооцоололыг тусламж үйлчилгээ үзүүлсэн өртөгт тодотгон тусгасан боловч бодитой бус , хязгаарлагдмал |
| **Нийгэм, улс төрийн хүчин зүйлс** | |
| - Хүн ам төвлөрсөн.<br>- Орон нутгийн эрүүл мэндийн салбарт хөрөнгө оруулалт нэмэгдэж байна.<br>- Гүйцэтгэлээрээ санхүүжих, эмнэлэг хагас бие даасан байдалд шилжих шилжилтүүд үе шаттай хэрэгжиж эхэлсэн. | - Хүн амын шилжилт хөдөлгөөн их, явуулын хүн ам ихтэй<br>- Хүн амын тоо жилээс жилд өсч байна. 2024 оны байдлаар хүн ам-105.900<br>- Үнийн өсөлт<br>- Шинэ төгсөгчдийн боловсролын чанар<br>- Хүний нөөцийн дутагдал<br>- Ажилгүй иргэд эрүүл мэндийн даатгалд хамрагддаггүй тул эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авч чадахгүй байх |
| **Гадаад харилцаа, түншлэл** | |
| - ДЭМБ, Жайка ОУ-ын байгууллага, Глобаль | - Гадаадад тэтгэлгээр сургах боломж гарахад |

| | |
|---|---|
| сан зэрэг байгууллагуудтай хамтран ажилладаг<br>- Гадаад улс оронд эмч, эмнэлгийн ажиллагсад уулзалт, семинарт оролцож мэдлэг мэргэжлээ дээшлүүлэхэд орон нутгаас дэмжлэг үзүүлэх<br>- Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаанд төр засаг, яам, агентлаг, төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, иргэд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, хамтын ажиллагааг өргөжүүлэх<br>- Олон улсын байгууллагаас төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, сургалт, семинар явуулах зэргээр дэмжлэг туслалцаа авах<br>- Өндөр хөгжилтэй улс орнуудтай гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх | эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн англи хэл хангалтгүй.<br>- Хамтын ажиллагаа сайн хөгжөөгүй, санхүүгийн тусламж үзүүлэх боломж хязгаарлагдмал<br>- Байгууллагын бүтээмж инновацийн хөгжүүлэлт хийгдэж эхэлсэн хэдий ч шинэ дэвшилтэт технологи нэвтрүүлэх, өндөр үнэтэй тоног төхөөрөмж ашиглах, түүний насжилт, урсгал болон их засварт шаардагдах төсөв санхүү хязгаарлагдмал |
| **Технологийн хүчин зүйлс** | |
| - Бусад хамтрагч талуудтай харилцаа холбоо тогтоох, цахим мэдээлэл солилцох боломжтой.<br>- "Цахим эрүүл мэнд" хөтөлбөр хэрэгжиж байна.<br>- Байгууллагын тусламж үйлчилгээ, хүний нөөц, санхүүгийн үйл ажиллагааны мэдээллийн ил тод байдал хангагдсан. /цахим хуудастай, шилэн дансанд мэдээллийг тогтмол байршуулдаг/<br>- Байгууллага дотоод, гадаад сүлжээ, интернетэд бүрэн холбогдсон холбогдсон.<br>- Зайн сургалт хийгдэх нөхцөл боломжоор хангагдсан.<br>- Телемедицинээр зөвлөгөө авах<br>- Цахим бүртгэл,E-mongolia хяналт /эм, бүртгэл мэдээлэл, урьдчилан сэргийлэх үзлэг.гм/ | - Мэдээллийн технологийн бэлтгэгдсэн ажилтан хангалтгүй, цөөн, ажлын ачаалал их.<br>- Эрүүл мэндийн байгууллагуудад ашиглагдаж буй программ хангамжууд харилцан хөрвөх мэдээ солилцох талаасаа хангалтгүй.<br>- Кибер аюулгүй байдлын үнэлгээ хийгдээгүй |

## БҮСИЙН ОНОШИЛГОО ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН SWOT ШИНЖИЛГЭЭ

| ***Давуу тал*** | ***Сул тал*** |
|---|---|
| - Байгууллагын алсын хараа, эрхэм зорилго, зорилт, үнэт зүйлээ тодорхойлсон. Байгууллагын стратеги төлөвлөгөөг 5 жилээр төлөвлөн батлуулдаг. 2021-2024 оны стратеги төлөвлөгөөний хэрэгжилт 81.3% үнэлэгдсэн.<br>- Байгууллагын үндсэн үйл ажиллагааны Гүйцэтгэлийн төлөвлөгөөг жил бүр Эрүүл мэндийн сайдаар хянуулан хэрэгжүүлж ажилладаг ба 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилт 93.1% үнэлэгдсэн.<br>- Төрөлжсөн нарийн мэргэжлийн эмч сувилагч нарын хүний нөөцийн хангалт 90-95%.<br>- Үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн, анагаах ухааны нотолгоонд суурилсан аргаар, чанартай, аюулгүй тусламж үйлчилгээ хүргэх чиглэлээр зүрх судас, гэмтэл согог засал, бөдүүн, шулуун гэдэс, бөөр шээсний замын тусламж үйлчилгээнд дэвшилтэт технологи нэвтрүүлж иргэд орон нутагтаа төрөлжсөн нарийн мэргжлийн тусламж үйлчилгээ авах боломжийг бүрдүүлж төвлөрлийг бууруулан ажиллаж байна. /өвдөгний үений дуран, шээлгүүрийн дуран, аминд аюултай хэм алдагдлын үед түр | - Сувилахуйн хүний нөөцийн шилжилт хөдөлгөөн их. Үүнд: сувилагч эмчээр сурахаар явах, жирэмсний болон хүүхэд асрах чөлөөтэй байх асуудлууд нөлөөлөх хүчин зүйл болдог<br>- Гүйцэтгэлийн санхүүжилтийн зарчмыг нэвтрүүлэхэд мөрдөгдөх журам зааврууд нь богино хугацаанд шинэчлэгдэх, шинээр хэрэгжих арга аргачлалд нөхцөл байдлаас шалтгаалж өөрчлөлт орох, эмнэлзүйн практикт нийцэхгүй байх<br>- Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагыг гэрээнд заасан оношийн хамаарлат бүлгээр хязгаарлаж тусламж үйлчилгээний нэр төрөл, хүртээмжийг хумих<br>- Инфляцийн өсөлттэй оношийн хамараалтай бүлгийн өртгийн жин тохирохгүй байх зэрэг шалтгаануудын улмаас тусламж үйлчилгээний зардлаа бүрэн нэхэмжилж авч чадахгүй санхүүгийн эрсдэл үүсэх<br>- Байгууллагад өр авлага үүсэх<br>- Нэн шаардлагатай тоног төхөөрөмжийн |

| | |
|---|---|
| зуурын пэйсмэйкер/<br>- Орон нутагт анх удаа тархины цус харвалт, зүрхний шигдээсийн нэгжийг байгуулж тодорхой үр дүнтэй ажиллаж байгаа.<br>- Ажлын хамт олон зохих түвшинд зөв төлөвшсөн, мэдлэг ур чадвар сайн, хөрвөх чадвартай<br>- Удирдлагын баг сайн бүрдсэн ба өөрчлөлт шинэчлэлт, менежментийг дэмждэг.<br>- Техник тоног төхөөрөмж, программ хангамж зохих түвшинд хангагдсан. | хэрэгцээ их<br>- Иргэд байгууллагын үйл ажиллагааны зарчмыг ойлгохгүй, өөрийн хүссэнээр байлгах гэж дарамтлах, эмч, сувилагчийн нэр хүндэд халдах буруу ташаа мэдээлэл нийтийн сүлжээнд тавих<br>- Интернэт, цахим сүлжээгээр эзэнгүй худал мэдээлэл тархаснаас байгууллагын нэр хүнд унах |
| ***Боломж*** | ***Аюул*** |
| - Аймгийн ИТХ, ЗДТГ-ын зүгээс дэмжлэг сайн үзүүлдэг.<br>- Олон улсын төсөл хөтөлбөрөөр хөрөнгө оруулалтыг татах боломжтой<br>- Чадварлаг мэргэшсэн баг бүрдсэн<br>- Хариуцлага, урамшууллын систем нэвтрүүлэх боломжтой<br>- Гадаад харилцаа өргөжүүлэх, туршлага солилцох боломжтой<br>- Үйл ажиллагааны процессыг хөнгөвчлөх боломжтой.<br>- Шинэчлэг үйлчилгээ, орчин үеийн менежмент нэвтрүүлэх боломжтой. | - Гүйцэтгэлийн санхүүжилтийг бүрэн төвлөрүүлэхэд нөлөөлж буй дотоод гадаад хүчин зүйлсийн нөлөөгөөр өр төлбөр, авлага үүсэх, өр төлбөр, авлагийн насжилт уртсах<br>- Өр авлага бууруулах арга хэмжээтэй холбоотой иргэн даатгуулагчийн эрх ашиг хөндөгдөх, тусламж үйлчилгээний тасралтгүй хэвийн байдал алдагдах<br>- Эмнэлэг үйлчилгээний доголдол бүртгэгдэх |

## ДӨРӨВ. БҮСИЙН ОНОШИЛГОО ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН АЛСЫН ХАРАА, ЭРХЭМ ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ҮНЭТ ЗҮЙЛ

***Алсын харaа:*** Дэвшилтэд технологи нэвтрүүлсэн оношилгоо, эмчилгээний цогц төв байх

***Эрхэм зорилго:*** Ажлын таатай нөхцөл, дэмжлэгт удирдлага, чадварлаг боловсон хүчний багаар сэтгэлд нийцсэн тусламж үзүүлнэ.

***Үнэт зүйл :*** Мэргэжлийн өндөр түвшинд чин сэтгэлээсээ үйчлилнэ

**Стратегийн тэргүүлэх чиглэл:**

1. Байгууллагын үйл ажиллагааны хөгжлийг дэмжих,удирдлага зохион байгуулалтыг боловсронгуй болгох
2. Эмнэлгийн тусламж үйлчилгээний стратеги
3. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний стратеги
4. Хүний нөөцийн хөгжлийн стратеги
5. Эрүүл мэндийн мэдээлэл технологийг хөгжүүлэх стратеги
6. Эмнэлгийн бие даасан байдал, санхүүгийн тогтвортой байдлыг хангах стратеги
7. Байгууллагын дэд бүтцийг хөгжүүлэх стратеги

***Баримтлах зарчим:***

- Эмнэлгийн болон нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлэх
- Хэнийг ч орхигдуулахгүй байх нэгдсэн зарчимд тулгуурлан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тэгш, хүртээмжтэй хүргэж чанарын стандартыг нэвтрүүлэх, чанар сайжруулах арга хэрэгслийг үйл ажиллагаандаа тасралтгүй хэрэгжүүлж түгээн дэлгэрүүлэх
- Хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх
- Нотолгоонд суурилсан анагаах ухааныг хөгжүүлэх
- Оношилгоо, эмчилгээнд шинэ дэвшилтэт технологи, тоног төхөөрөмжийг нэвтрүүлж нутагшуулах
- Үйлчлүүлэгч төвтэй үйлчилгээний соёлыг хөгжүүлэх, үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах

- Халдварын сэргийлэлт хяналтын тогтолцоог бэхжүүлэх
- Эмнэлгийн хагас бие даасан байдлыг хөгжүүлэх, байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг оновчтой төлөвлөн зохион байгуулах, үр ашиггүй зардлыг бууруулах
- Гадаад, дотоодын хамтын ажиллагааг өргөжүүлэх

***<u>Хэрэгжүүлэх хугацаа</u>:*** 2025-2029 он

## ТАВ. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО, ЧИГЛЭЛ БА ЗОРИЛТУУД:

**5.1. Стратегийн зорилго:** Байгууллагын чадавхийг бэхжүүлэх, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах, хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, оношилгоо эмчилгээний шинэ дэвшилтэт технологийг нэвтрүүлж нутагшуулах, эмч, эмнэлгийн ажиллагсдын мэдлэг, ур чадвар, боловсролын түвшинг тасралтгүй хөгжүүлэх, тэдгээрийн нийгмийн баталгаа хангах чиглэлээр үе шаттай арга хэмжээ төлөвлөн хэрэгжүүлэхэд оршино.

**5.2.Тэргүүлэх чиглэл**: "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Засгийн газрын 2025-2029 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Орхон аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Орхон аймгийн Засаг даргын 2025-2029 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийг хангах зорилго, зорилтуудад үндэслэн Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлов.

1. Байгууллагын үйл ажиллагааны хөгжлийг дэмжих,удирдлага зохион байгуулалтыг боловсронгуй болгох
2. Иргэдэд нэн шаардлагатай эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанартай хүртээмжтэй хүргэх, эмчилгээ оношилгоонд шинэ дэвшилтэт технологи нэвтрүүлж, нутагшуулах, шаардлагагүй хэвтэлт, үр ашиггүй тусламж, үйлчилгээг бууруулах, төвлөрлийг сааруулах, иргэдийг санхүүгийн эрсдэлээс хамгаалах замаар хүн амын дундаж наслалтыг нэмэгдүүлэх, нас баралтыг бууруулах
3. Төрийн болон төрийн бус байгууллагуудын идэвхи санаачилга, олон улсын улсын байгууллагуудын дэмжлэг туслалцаа, иргэд, аж ахуйн нэгжийн байгууллагын оролцоотойгоор нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хөгжүүлж эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэх, оношлох, хяналтад авах, эмчлэн эрүүлжүүлэх чадавхийг бэхжүүлэх
4. Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн мэдлэг, ур чадварыг хөгжүүлэх нөхцөл боломжийг тасралтгүй бүрдүүлэх, нийгмийн баталгаа хангах, тэдгээрийн эрүүл аюулгүй, тав тухтай ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлэх
5. Байгууллагын үйл ажиллагаанд цахим үйлчилгээг өргөжүүлэн, эрүүл мэндийн мэдээллийн сан бүрдүүлэх, орон нутагт хийгдэх оношилгоо эмчилгээнд алсын зайн технологи ашиглаж, цахим эрт илрүүлэг, эргэн дуудах тогтолцоог бүрдүүлэх
6. Эмнэлгийн хагас бие даасан байдлыг хөгжүүлэх, байгууллагын хөрөнгө оруулалт, санхүүжилтийг оновчтой төлөвлөх, санхүүгийн үр ашгийг нэмэгдүүлэх замаар гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн зарчмыг бүрэн хэрэгжүүлэх
7. Байгууллагын дэд бүтцийг хөгжүүлж үйл ажиллагааны менежментийг сайжруулах

### 5.2. СТРАТЕГИЙН ЧИГЛЭЛ БА ЗОРИЛТУУД:

### 5.2.1. Байгууллагын үйл ажиллагааны хөгжлийг дэмжих, удирдлага зохион байгуулалтыг боловсронгуй болгох стратеги

**СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 5.2.1.1**. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд чанарын стандартыг нэвтрүүлэхийн зэрэгцээ чанар сайжруулах арга хэрэгслийг үйл ажиллагаандаа тасралтгүй ашиглах тогтолцоог бэхжүүлнэ.

**Хүрэх үр дүн:** Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж нэмэгдэнэ, эрсдлээс сэргийлнэ

**СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 5.2.1.2.** Халдварын сэргийлэлт хяналтын тогтолцоог бэхжүүлж ЭТҮХХ-ын эрсдлийг бууруулж ажиллана.

**Хүрэх үр дүн:** Эмч, эмнэлгийн ажилтнууд болон үйлчлүүлэгчдийг ЭТҮХХ-той халдвараас сэргийлэх хяналтын тогтолцоо бэхжинэ.

**СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 5.2.1.3.** Эмнэлгийн тусламж үйлчилгээнд нэн шаардлагатай тоног төхөөрөмж, эм эмнэлгийн хэрэгслээр тасралтгүй хангана.

**Хүрэх үр дүн:** Эмчилгээ оношилгоонд шинэ дэвшилтэт технологийг нэвтрүүлж үйлчүүлэгчдийг орон нутагтаа төрөлжсөн нарийн мэргжлийн тусламж үйлчилгээ авах нөхцлийг бүрдүүлнэ.

**СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 5.2.1.4.** Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага MNS 7014:2023 стандартын хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллана.

**Хүрэх үр дүн:** Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж дээшилж байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал хангагдаж иргэдэд ойлгомжтой хүлээгдэл, чирэгдэлгүй үйлчилгээ үзүүлнэ.

### 5.2.2 ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СТРАТЕГИ

**СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 5.2.2.1.** Бүсийн түвшинд Хавдрын оношилгоо эмчилгээ, хяналт–сэргийлэлт, Яаралтай тусламж, Пренатал оношилгоо, Зүрхний төвүүдийг байгуулж үйл ажиллагааг жигдрүүлнэ.

**Хүрэх үр дүн**: Хүн амын өвчлөл, нас баралтын тэргүүлэх шалтгааныг бууруулахад чиглэсэн арга хэмжээг судалгаа шинжилгээ, эрүүл мэндийн статистик үзүүлэлтэд үндэслэн хэрэгжүүлэх замаар дундаж наслалтыг нэмэгдүүлэх, нас баралтыг бууруулах, төвлөрлийг сааруулах бодлогыг орон нутагт хэрэгжүүлж Монгол улсын урт болон дунд хугацааны бодлогын бичиг баримтад тусгагдсан эрүүл мэндийн салбарын зорилго, зорилтуудыг хэрэгжүүлж ажилласан байна.

**СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 5.2.2.2** Ерөнхий мэс заслын тусламж үйлчилгээг хөгжүүлж шинэ дэвшилтэт технологийг нутагшуулна

**Хүрэх үр дүн:** Мэс заслын үеийн тусламж үйлчилгээний чанар хүртээмж нэмэгдэж эмчилгээ, оношилгооны хожимдлоос сэргийлнэ.

**СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 5.2.2.3** Орон нутагт эмчлэх, оношлох боломжгүй тусламж үйлчилгээг нутагшуулж шинэ дэвшилтэт технологийг нэвтрүүлнэ.

**Хүрэх үр дүн:** Иргэд орон нутагтаа төрөлжсөн мэргэшлийн тусламж үйлчилгээнд цаг алдалгүй хамрагдаж амь нас эрүүл мэндээ хамгаалуулах тогтолцоо бүрдэж санхүүгийн эрсдлээс сэргийлэгдэнэ.

### 5.2.3 НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СТРАТЕГИ

**СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 5.2.3.1** Байгууллагын түвшинд Нийгмийн эрүүл мэндийг дэмжих орон тооны бус алба байгуулагдана.

**Хүрэх үр дүн**: Нийгмийн эрүүл мэндийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийг хангаж нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг өргөжүүлнэ.

**СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 5.2.3.2** Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, иргэн бүр урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд тогтмол хамрагдах нөхцөлийг сайжруулж, нотолгоонд суурилсан эрүүл мэндийг дэмжих бодлогыг хэрэгжүүлнэ.

**Хүрэх үр дүн:** Иргэдийг өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, оношилгоо, хяналтад авах, эмчилгээний хожимдолгүй эрт үед эмчлэн эрүүлжүүлэх тогтолцоог бэхжүүлсэн байна.

**СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 5.2.3.3** Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, гамшиг, онцгой байдлын үед урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэх чадавхыг бэхжүүлнэ.

**Хүрэх үр дүн:** Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, гамшиг байдлын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний бэлэн байдлыг хангаж эмч, мэргэжилтнүүдийг чадавхжуулсан байна.

### 5.2.4. ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ

**СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 5.2.4.1** Эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг тасралтгүй хөгжүүлэх, залгамж халаа бэлтгэх дэд хөтөлбөр батлуулан хэрэгжилтийг ханган ажиллана

**Хүрэх үр дүн:** Байгууллагын хүний нөөцийн тогтвортой, тасралтгүй байдал хангагдаж ажилчдын сэтгэл ханамж дээшилнэ.

**СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 5.2.4.2** Эрүүл мэндийн ажилтны нийгмийн баталгаа сайжруулан, урамшууллын тогтолцоог боловсронгуй болгон, тэдний эрүүл аюулгүй тав тухтай ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.

**Хүрэх үр дүн:** Мэдлэг чадвартай хүний нөөцийн хангалт нэмэгдэж, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бүрдэнэ.

### 5.2.5 .ЭРҮҮЛ МЭНДИЙН МЭДЭЭЛЭЛ, ТЕХНОЛОГИЙГ ХӨГЖҮҮЛЭХ СТРАТЕГИ

**СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 5.2.5.1** Эрүүл мэндийн салбарт хийгдэж буй цахим шинэчлэлтийг байгууллагын үйл ажиллагаанд тухай бүр нэвтрүүлж сүлжээ, сервер, программын цахим аюулгүй байдлыг хангах, хөгжүүлэх технологийн шинэчлэл хийх

**Хүрэх үр дүн:** Мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашиглан хүн амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг орон зай, цаг хугацаанаас үл хамааран тэгш, хүртээмжтэй, чанартай, шуурхай хүргэдэг болно.

### 5.2.6 Эмнэлгийн хагас бие даасан байдал, санхүүгийн тогтвортой байдлыг хангах стратеги

**СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 5.2.6.1** Эмнэлгийн хагас бие даасан байдлыг хангах эрхзүйн орчныг бүрдүүлнэ.

**Хүрэх үр дүн:** Төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан төсвийн хуваарийн дагуу эмнэлгийн төсвийг захиран зарцуулах,төсвийг үр ашигтай зарцуулж, хэмнэсэн зардлыг тусламж, үйлчилгээний чанарыг дээшлүүлэх, ажилтны нийгмийн баталгаа хангах, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхжуулах үйл ажиллагаанд зарцуулдаг тогтолцоог бэхжүүлнэ.

**СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 5.2.6.2** Байгууллагын санхүүгийн удирдлагыг үр дүнтэй хэрэгжүүлнэ

**Хүрэх үр дүн:** Байгууллагын санхүүгийн ил тод байдал хангагдан, төсвийн сахилга бат хариуцлага дээшилнэ.

### 5.2.7.Байгууллагын дэд бүтцийг хөгжүүлэх стратеги

**СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 5.2.7.1** Байгууллагын барилга байгууламж, дэд бүтцийг хөгжүүлж эрүүл аюулгүй ажлын байр, эмнэлгийн орчныг бүрдүүлнэ.
**Хүрэх үр дүн:** Байгууллагын дэд бүтцийг үе шаттай төлөвлөн хөгжүүлж хамтын ажиллагааг хангаж ажилласан байна.

## Зургаа. Байгууллагын үйл ажиллагааны чиг үүрэг, бүтцийн уялдаа, зураглал

Бүсийн оншилгоо эмчилгээний төв нь Монгол Улсын Засгийн газрын 2001 оны 194-р тогтоолын 2-р хавсралт, “Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн дүрэм”, Монгол Улсын Засгийн газрын 2008 оны “Орхон аймагт Бүсийн оношилгоо, эмчилгээний төв байгуулах тухай” 56 дугаар тогтоол, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 2022 оны А/78 дугаар тушаалаар удирдах болон гүйцэтгэх, үйлчлэх 536 ажиллагсадтай, 8 алба, 26 тасаг нэгж, 32 үзлэгийн кабинет, 433 эмнэлгийн ортойгоор эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна.

## НЭГ. УДИРДЛАГЫН ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЧИГ ҮҮРЭГ:

1.1 Төрийн албаны тогтвортой байдал, удирдлагын манлайллыг хангаж, албан хаагчдын ажлын үр нөлөө, ур чадвар, чадавхийг бэхжүүлж, байгууллагын алсын хараа, зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэх, мэргэшсэн чадварлаг аппарат бүрдүүлэх, эрүүл мэндийн чиглэлээрх хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, тайлагнах, авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, үйл ажиллагааны ил тод байдлыг хангах ажлыг төлөвлөх, зохицуулах, тайлагнах, хүний нөөцийн бодлогыг төлөвлөх, хөгжүүлэх, ажиллагсдын боловсрол, мэргэжлийн зэргийг тасралтгүй дээшлүүлэх, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн багц цагийн биелэлтэнд хяналт тавих, эрүүл мэндийн ажилтны ажиллах нөхцөл нийгмийн баталгааг дэмжих, урамшуулах, эмнэлгийн бие хагас даасан байдлыг хөгжүүлэх, санхүү, хөрөнгө оруулалтын хэрэгцээг тодорхойлж, төсвийн төлөвлөлтийг оновчтой төлөвлөн, биелэлтийг хангуулах, тайлагнах, хөрөнгө оруулалт, зээл, тусламжийн хэрэгцээнд дүн шинжилгээ хийх, санхүү, төсвийн ил тод байдлыг хангах, санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэг хэрэгжүүлнэ.

1.2 Байгууллагын удирдлага зохион байгуулалт бүтэц, орон тоо, төсвийг жил бүр хэлэлцэн шийдвэр гаргах, төвийн хэмжээнд нийтээр дагаж мөрдөх заавар журам, тушаал шийдвэрийн төслийг боловсруулан хэлэлцэн батлах

1.3 Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн захирлын Эрүүл мэндийн сайдаар хянуулах “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”- г тухайн жилийн 01дүгээр сарын 15-ны дотор хянуулан батлуулж хагас жил тутамд биелэлтийг дүгнэх, тайлагнах

1.4 Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмж, өвчлөлийн статистик үзүүлэлт, эмнэлэг үйлчилгээний доголдол, эмнэлгийн нас баралт, үйлчилгээний соёлын стандартыг улирал тутам хэлэлцэж тусламж үйлчилгээний тасралтгүй бэлэн байдлыг хангахад шаардлагатай хүний нөөц, санхүү, хөрөнгө, техник, тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгслийн хангалт, сүлжээ, программ хангамж, цахим аюулгүй байдал, засвар үйлчилгээний асуудлыг тухай бүр шийдвэрлэх

1.5 Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн дэд захирлууд, албадын дарга нар, тасгийн эрхлэгч нарын гүйцэтгэлийн төлөвлөгөө, ажлын тайланг улирал тутамд хэлэлцэх, хурлаас гарсан шийдвэрийг хүргүүлж хэрэгжилтийг хангуулах

1.6 Тасаг нэгжүүдийн гүйцэтгэлийн санхүүжилтийн тайланг улирал тутам хэлэлцэж төсвийн төлөвлөлтийн биелэлтийг хангуулах, санхүү, хөрөнгө мөнгө зарцуулахтай холбогдсон асуудлыг тухай бүр шийдвэрлэх

1.7 Ажилтан шинээр ажилд авах, дотроо шилжүүлэн ажиллуулах, ажлаас халах, сахилгын шийтгэл ногдуулах, шагнах, урамшуулах, төрийн дээд байгууллага болон бусад шагналд тодорхойлох, тэтгэвэр тэтгэмж олгохтой холбоотой асуудлыг хэлэлцэх

1.8 Гадаад, дотоодын гэрээ, хэлэлцээрийн төсөл, түүний явц хэрэгжилт, гэрээт ажлуудын гэрээний биелэлт, гүйцэтгэлийн үр дүнг хэлэлцэх

1.9 Бусад тусгайлсан асуудлаар комисс, зөвлөл, ажлын хэсэг байгуулах түүний ажлын үр дүнг хэлэлцэж, дүгнэх

## ХОЁР. ЭМНЭЛЗҮЙ ЭРХЭЛСЭН ДЭД ЗАХИРЛЫН АЖИЛЛАХ ЧИГ ҮҮРЭГ:

2.2 Аймгийн болон үйлчлэх хүрээний хүн амд хүртээмжтэй, чанартай, аюулгүй өргөн хүрээний тусламж, үйлчилгээг үзүүлэх бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, анхан шатны болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага хоорондын уялдаа холбоог хангаж мэргэжил аргазүйн дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах,

2.3 Эмчилгээ, оношилгооны стандарт, удирдамжийн хэрэгжилтийг хангуулах, үнэлгээ дүгнэлт хийх , хяналт тавих арга хэмжээг зохион байгуулах

2.4 Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдал, эрсдлээс сэргийлэх чиглэлээр удирдамж, журам, зөвлөмж боловсруулан хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах

2.5 Эмчилгээ оношилгооны шинэ дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, шаардлагагүй хэвтэлт, үр ашиггүй тусламж үйлчилгээг бууруулах зохицуулах чиг үүрэг хэрэгжүүлэх
2.6 Эмзүйн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг хангаж эмчилгээний өндөр идэвхитэй, чанарын баталгаатай, аюулгүй, эдийн засгийн үр ашигтай, эм эмнэлгийн хэрэгслээр хангах арга хэмжээнд хяналт тавьж хэрэгжилтийг хангуулах
2.7 Тусламж үйлчилгээний үндсэн үзүүлэлт, өвчлөлийн статистик үзүүлэлтэд сар бүр дүн шинжилгээ хийж сайжруулах санал шийдвэрийн төслийг байгууллагын захирал болон удирдлагын зөвлөлд тухай бүр танилцуулан шийдвэрлэж ажиллах
2.8 Тусламж үйлчилгээний чанар сайжруулах чиглэлээр ажиллаж буй зөвлөл, комиссын үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж улирал бүр хуралдуулан нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангаж үйл ажиллагааны үр дүнг дүгнэх , сайжруулах санал шийдвэрийн төслийг байгууллагын захирал болон удирдлагын зөвлөлд тухай бүр танилцуулан шийдвэрлэж ажиллах
2.9 Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, чанар аюулгүй байдлын албаны хурлаас гарсан шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг зохион байгуулж шийдвэрлэн ажиллах
2.10 Тасаг нэгжүүдийн үйл ажиллагаанд өдөр тутам хяналт тавьж анхаарал татсан, биеийн байдал хүнд өвчтөнүүдэд эмч нарын хамтарсан болон нарийн мэргэжлийн эмч нарын үзлэг хийх үйл ажиллагааг удирдан зохион байгуулж нэгдсэн удирдлагаар хангах, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих
2.11 Эмнэлгийн яаралтай, түргэн тусламжийн тасгийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж амь тэнссэн үеийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, эрсдлээс сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх\
2.12 Эмгэг судлал, эмнэлзүйн зөвөлгөөн, үндсэн оношийн зөрүү, эмнэлэг үйлчилгээний доголдол, ховор тохиолдлыг ЭТҮЧАБА-тай хамтран улирал бүр хэлэлцэж сайжруулах санал шийдвэрийн төслийг байгууллагын захирал болон удирдлагын зөвлөлд тухай бүр танилцуулан шийдвэрлэж ажиллах
2.13 Эмнэлэг үйлчилгээний доголдлыг эмч мэргэжилтнүүдэд мэдээллэх, хариуцлага тооцох, алдаанаас суралцах, мэдлэг ур чадварыг нэмэгдүүлэх сургалтыг СЭШИА-тай хамтран тасралтгүй зохион байгуулах
2.14 Иргэн даатгуулагчид үзүүлж буй тусламж үйчилгээний чанарт улирал бүр хөндлөнгийн хяналт үнэлгээ хийж чанар сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх , санхүүгийн эрсдлээс сэргийлэх

## ГУРАВ. ТӨЛӨВЛӨЛТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЭЛСЭН ДЭД ЗАХИРЛЫН АЖИЛЛАХ ЧИГ ҮҮРЭГ

3.1 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, тооцоо, зураг төсөв, техникийн үзүүлэлтийг бэлтгэх, худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулах
3.2 Байгууллагын хөрөнгө оруулалт, эдийн засаг, санхүүжилттэй холбоотой судалгаа, дүн шинжилгээ хийх, байгууллагын зорилго, зорилт стратеги-ийн тэргүүлэх чиглэлийг дэмжсэн санхүүжилтийн үр ашигтай тогтолцоог бүрдүүлэх
3.3 Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн шинэчлэлийг дэмжих үйл ажиллагааг тогтмол зохион байгуулж байгууллагын гүйцэтгэлийн санхүүжилтийг бүрэн төвлөрүүлэх үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах
3.4 Тусламж, үйлчилгээний тасралтгүй хэвийн үйл ажиллагаа тоног төхөөрөмж, цахим мэдээлэл технологийн хөгжил, аюулгүй байдал, цахилгаан, дулаан, сангийн аюулгүй ажиллагааг бүрэн хариуцаж нэгдсэн удирдлагаар хангах
3.5 Эмнэлгийн тоног төхөөрөмжийг хүлээн авах, суурилуулах, үйл ажиллагаанд оруулах, аюулгүй ажиллагааны зааварчилга өгөх, үзлэг үйлчилгээ хийх, холбогдох маягт, баримт бичгүүдийг стандартын дагуу хөтөлж тоног төхөөрөмжийн хангалт, хэрэгцээг тодорхойлж удирдлагыг мэдээллээр хангах
3.6 Эмнэлгийн дэмжих үйлчилгээг удирдлага зохион байгуулалтаар хангаж бусад алба, тасаг нэгжүүдийн үйл ажиллагаатай уялдуулж ажиллах

3.7 Эмнэлгийн мэргэжилтэний төгсөлтийн дараах сургалт, тасралтгүй сургалтыг зохион байгуулах, эрдэм шинжилгээ, судалгааны ажил, хамтын ажиллагаа, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээг байгууллагын зорилго, зорилттой уялдуулан зохион байгуулж нэгдсэн удирдлагаар хангах

3.8 НЭМ-ийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангаж, сайжруулах санал шийдвэрийн төслийг байгууллагын захирал болон удирдлагын зөвлөлд тухай бүр танилцуулан шийдвэрлэж ажиллах

3.9 Байгууллагын гадаад болон дотоод орчинг иргэд үйлчлүүлэгчид ээлтэй, аюулгүй, эрүүл ахуйн шаардлага хангасан нөхцлөөр хангах арга хэмжээг хариуцан зохион байгуулах

3.10 Байгууллагын хөрөнгө, эд хогшлыг хамгаалах, эрсдлээс сэргийлэх арга хэмжээг нэгдсэн удирдлагаар хангаж, сайжруулах санал шийдвэрийн төслийг байгууллагын захирал болон удирдлагын зөвлөлд тухай бүр танилцуулан шийдвэрлэж ажиллах

3.11 Гамшгийн менежмент, онцгой байдлын үед авах арга хэмжээний төлөвлөгөө, хөтөлбөрийг хүний нөөцийн албатай хамтран боловсруулж хэрэгжилтийг зохион байгуулах

## <u>ДӨРӨВ . САНХҮҮ БҮРТГЭЛИЙН АЛБАНЫ АЖИЛЛАХ ЧИГ ҮҮРЭГ</u>

4.1 Байгууллагын эдийн засаг, санхүү, хөрөнгө оруулалтын хэрэгцээг тодорхойлж, төсвийн төслийг боловсруулах, батлуулах биелэлтийг хангуулах, тайлагнах арга хэмжээг нэгдсэн удирдлагаар хангаж, сайжруулах санал шийдвэрийн төслийг байгууллагын захирал болон удирдлагын зөвлөлд тухай бүр танилцуулан шийдвэрлэж ажиллах

4.2 Эмнэлгийн үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангаж үйл ажиллагааны үр дүн болон үйл ажиллагааны нэгжийн өртөг зардлыг тооцох, төсвийн үр ашгийг сайжруулах арга хэмжээг тогтмол зохион байгуулах

4.3 Хамтран ажиллах байгууллагуудтай гэрээ хийж гэрээний хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг нэгдсэн удирдлагаар хангах, сайжруулах санал шийдвэрийн төслийг байгууллагын захирал болон удирдлагын зөвлөлд тухай бүр танилцуулан шийдвэрлэж ажиллах

4.4 Монгол улсад мөрдөгдөж байгаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон бусад холбогдох эрхзүйн акт, шийдвэрийг хэрэгжүүлэх, шийдвэр гаргахад ач холбогдолтой, үнэн зөв мэдээллээр удирдлагыг хангах

4.5 Салбарын санхүүжилтийн шинэчлэл, гүйцэтгэлийн санхүүжилттэй уялдуулан тусламж үйлчилгээний хүрээ, тоо хэмжээ, төлбөрийн аргад суурилан төсвийн төлөвлөлтийг хийх

4.6 УСНББОУС, СТОУС, Сангийн сайдын төсөвт байгууллагын санхүүгийн тайлан бэлтгэх зааврын дагуу санхүүгийн тайлан боловсруулах, тайлагнах.

4.7 Төсвийн гүйцэтгэл нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналыг санхүүгийн бүртгэлийн нэгдсэн мэдээллийн сүлжээгээр хангах, мэдээллийн санг бүрдүүлэх, санхүү нягтлан бодох бүртгэлийн цахим системийг хөгжүүлэх.

4.8 Төсвийн хөрөнгийн үр ашигтай зарцуулалт, удирдлагын шийдвэр ил тод, нээлттэй, олон нийтийн хяналттай байх зарчмын хүрээнд Шилэн дансны тухай хуулийн дагуу төсөв, санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг цаг хугацаанд нь цахим хуудсанд байршуулах.

4.9 Байгууллагын үндсэн хөрөнгө, бараа материал, үл хөдлөх хөрөнгөтөй холбоотой төрийн өмчийн бодлогыг хэрэгжүүлэх, бүртгэх, тооллого хийх, хадгалалт ашиглалтанд хяналт тавих, Өмч хамгаалах комисс, Төрийн өмчийн газарт актлах хөрөнгийг танилцуулах, шийдвэрлүүлэх.

4.10 Төсвийн өглөг, авлагын төлбөр тооцоог бүртгэх, хянах, өр төлбөр, авлагыг бууруулах, найдваргүй авлага, өр төлбөрийг удирдлагын зөвлөлд танилцуулах, шийдвэрлүүлэх

## ТАВ . ХҮНИЙ НӨӨЦИЙН АЛБАНЫ АЖИЛЛАХ ЧИГ ҮҮРЭГ

5.1 Салбарын хүний нөөцийн бодлого, стратеги-тэй уялдуулан байгууллагын хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлох, тэдгээрийн хөгжих, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах чиглэлээр богино болон урт хугацааны төлөвлөгөөг боловсруулж хэрэгжилтийг зохион байгуулах, хүний нөөцийн тасралтгүй байдал, залгамж халааг бэлтгэх

5.2 Байгууллагын дотоод журам, хамтын гэрээг нийт ажилчдад нээлттэй танилцуулж хөдөлмөрийн харилцааны холбогдох хуулиудыг чанд баримталж ажиллах

5.3 Ажилтнуудын албан тушаалын тодорхойлолтыг боловсруулж, шинэчлэх, ажил үүргийн хуваарилалтад үнэлгээ хийх, алба хаагчдын хувийн хэрэг, холбогдох баримт бичгийн бүрдүүлэлтийг стандартын дагуу бүрдүүлэх

5.4 Байгууллагын хүний нөөцийн бүрдүүлэлт, сонгон шалгаруулалтыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулах

5.5 Шинээр томилогдсон албан хаагчийг чиглүүлэх, дасан зохицуулах хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх

5.6 Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн чиглэлээр тасралтгүй сургалт зохион байгуулж, сахилга хариуцлагыг нэмэгдүүлэх

5.7 Цалин хөлс, урамшууллын системийг үнэлж, дүгнэх, байгууллагын удирдлагыг мэдээллээр хангах, гүйцэтгэлд суурилсан урамшууллын тогтолцоо бий болгож, хэрэгжүүлэх

5.8 Цалин хөлс, урамшуулалтай холбоотой дотоод журам, цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмж авах болзол, ажилласан жил, гүйцэтгэлийн үнэлгээнд үндэслэсэн цалин нэмэгдүүлэх арга хэмжээг удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх

5.9 Байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон хөдөлмөрийн аюулгүй байдал, ажил мэргэжлээс шалтгаасан осол, гэмтэл, хөдөлмөрийн чадвар алдахаас сэргийлэх хөтөлбөр, ажиллагсдын эрүүл мэндийг дэмжих хөтөлбөр, гамшгийн менежмент, онцгой байдлын үед авах арга хэмжээний хөтөлбөрийг тус тус боловсруулж хэрэгжилтийг зохион байгуулах

5.10 Тэтгэвэр, тэтгэмжийн төлөвлөгөө боловсруулж, залгамж халааг бэлтгэх арга хэмжээг төлөвлөн зохион байгуулах

5.11 Алба хаагчдын ажлын цаг ашиглалтанд хяналт тавих, холбогдох бүртгэл судалгааг тогтоосон хугацаанд гаргах

5.12 Ажилтнуудын сэтгэл ханамжийн судалгааг улирал бүр авч санал хүсэлт, гомдлын мөрөөр арга хэмжээний төвөлгөө боловсруулж хэрэгжилтийг зохион байгуулах

5.13 Архив, албан хэрэг хөтлөлтийн стандартыг хэрэгжилтийг хангах

5.14 Эмнэлгийн үйл ажиллагаатай холбоотой тушаал шийдвэрийн төслийг холбогдох албатай хамтран боловсруулж батлуулах, албан хаагчтай холбоотой шийдвэрийг гаргахад удирдлагад дэмжлэг үзүүлэх

## ЗУРГАА . ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ, ЧАНАР АЮУЛГҮЙ БАЙДЛЫН АЛБАНЫ АЖИЛЛАХ ЧИГ ҮҮРЭГ

6.1 Тусламж, үйлчилгээний чанарын удирдлагын тогтолцоонд нийцүүлэн, чанарыг тасралтгүй сайжруулах үйл ажиллагааг зохион байгуулах, чанар эрсдэл, үйлчлүүлэгчийн аюулгүй байдалд тогтмол хяналт, шинжилгээ, үнэлгээ хийж арга зүйн дэмжлэг үзүүлэх

6.2 Чанарын удирдлагын тогтолцооны чиглэлээр ажилладаг эрх бүхий байгууллагууд, үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын чиглэлээр ажилладаг төрийн болон төрийн бус байгууллага, зөвлөл, иргэдийн төлөөлөл олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах, сургалт, судалгаа хийх, туршлага судлах, зөвлөх үйлчилгээг зохион байгуулах

6.3 Чанар сайжруулах чиглэлээр ажилтнуудад сургалт, харилцан туршлага солилцох ажлыг тогтмол зохион байгуулж, тасралтгүй суралцах үйл ажиллагааг хэрэгжүүлэх

6.4 Тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын төлөвлөгөөг гарган, хэрэгжилтийг хангах, үнэлэлт дүгнэлт өгөх, түүний мөрөөр цаашид авах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах
6.5 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний стандарт, эмнэлзүйн удирдамж заавры г мөрдүүлэн, хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллах
6.6 Хөндлөнгийн хяналт, шинжилгээ, үнэлгээ, магадлан итгэмжлэл, мэргэжлийн хяналтын шалгалтын дүн, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах
6.7 Халдварын сэргийлэлт, хяналтын, эмчилгээний, ёс зүйн, эмийн болон бусад хороо, зөвлөл, албадуудтай хамтран ажиллаж үйл ажиллагаанд нь хяналт тавьж, чанар сайжруулах үйл ажиллагаанд татан оролцуулах
6.8 Үйлчлүүлэгчидтэй уулзалт, ярилцлага зохион байгуулах, сэтгэл ханамжийн судалгааг сар бүр зохион байгуулж түүний мөрөөр арга хэмжээ зохион байгуулах
6.9 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг сайжруулах олон улсын туршлагыг нэвтрүүлэх
6.10 Үйлчлүүлэгч болон эрүүл мэндийн мэргэжилтний аюулгүй байдлыг хангах, эрсдэлээс хамгаалах орчин бүрдүүлэхэд шаардлагатай зохицуулалтын талаар санал гаргаж, шийдвэрлүүлэх
6.11 Байгууллагын хэмжээнд чанар сайжруулах талаар хэрэгжүүлж буй бүх арга хэмжээг бүртгэн, мэдээллийн сан байгуулж олсон ололт амжилтыг байгууллагынхаа бүх тасаг/нэгжүүдэд дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулж урамшуулан ажиллах
6.12 Байгууллагын тусламж, үйлчилгээтэй холбоотойгоор иргэд, байгууллагаас ирсэн санал, гомдол, хүсэлтийг шийдвэрлэх, тэдний хүсэлтийг шийдвэр гаргалтанд тусгасан талаар эргэн мэдээлэх, өргөдөл, гомдол, санал хүсэлтийг сар бүр ажилтан албан хаагчдад танилцуулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмол зохион байгуулах
6.13 Шинэ ажилтанг чиглүүлэх сургалтын хөтөлбөрт чанар, үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын талаар тусгах, эмч, эмнэлгийн ажилтнуудад чанар, аюулгүй байдлын сургалтыг тогтмол зохион байгуулах
6.14 Иргэн даатгуулагчид үзүүлж буй тусламж үйчилгээний чанарт улирал бүр хөндлөнгийн хяналт үнэлгээ хийж чанар сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх, санхүүгийн эрсдлээс сэргийлэх
6.15 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын шалгуур үзүүлэлтэд дүн шинжилгээ хийж, байгууллагын тусламж үйлчилгээний чанар, үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын үйл ажиллагааг үнэлэх , түүний мөрөөр арга хэмжээ зохион байгуулах
6.16 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр байгууллагад мөрдөх дүрэм, журам заавар, хяналтын хуудсыг хуульд нийцүүлэн боловсруулан, мөрдүүлж, хэрэгжилтийг хангаж ажиллах
6.17 Эрүүл мэндийн мэргэжилтний ажлын гүйцэтгэлийн үнэлгээнд чанар аюулгүй байдлын ажлыг нэг шалгуур болгон оруулж дүгнэх
6.18 Байгууллагын соёл болон Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага MNS7014:2023 стандартын хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг нэгдсэн удирдлагаар хангаж, сайжруулах санал шийдвэрийн төслийг байгууллагын захирал болон удирдлагын зөвлөлд тухай бүр танилцуулан шийдвэрлэж ажиллах

## ДОЛОО . СУВИЛАХУЙН АЛБАНЫ АЖИЛЛАХ ЧИГ ҮҮРЭГ

7.1 Сувилагч , эх баригч, эмнэлгийн тусгай мэргэжилтэний үзүүлэх тусламж үйлчилгээг байгууллагын зорилго, зорилттой уялдуулан төлөвлөх, нэгдсэн удирдлагаар хангах, хэрэгжүүлэх
7.2 Сувилах, эх барихуйн тусламж үйлчилгээг хөгжүүлэх стратеги-ийн хэрэгжилтийг хангах, сувилах, эх барихуйн чанарын хөгжлийн төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх
7.3 Сувилагч , эх баригч, эмнэлгийн тусгай мэргэжилтэний үзүүлэх тусламж үйлчилгээний стандарт, дүрэм, журам, удирдамж, заавар, аргачлалын хэрэгжилтийг хангах, хяналт тавих, дэмжин туслах, аргазүйгээр хангах

7.4 Сувилагч , эх баригч, эмнэлгийн тусгай мэргэжилтэний үзүүлэх тусламж үйлчилгээний чиглэлээр удирдамж, заавар, аргачлал, хяналтын хуудсыг хуульд нийцүүлэн боловсруулан, мөрдүүлж, хэрэгжилтийг хангаж ажиллах
7.5 Сувилагч , эх баригч, эмнэлгийн тусгай мэргэжилтэний үзүүлэх тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал, халдварын сэргийлэлт хяналт, дотоод хяналт, эрсдлийн хэрэгжилтэд хяналт тавих, зөвлөмж боловсруулах, хэрэгжүүлэх, нэгдсэн удирдлагаар хангах
7.6 Сувилагч, тусгай мэргэжилтнүүдийн гардан үйлдэл , төрөлжсөн асаргаа сувилгаанд өдөр тутам хяналт тавих, чанар сайжруулах арга хэмжээг тогтмол зохион байгуулах
7.7 Сувилахуйн тусламж үйлчилгээний тохиолдол, эрсдлийг бүртгэх, эмнэл зүйн хэлэлцүүлэг , эрсдлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмол зохион байгуулах
7.8 Сувилагч, мэргэжилтнүүдийн ажлын ачааллыг тэнцвэржүүлэх олон талт ажиллагаа зохион байгуулах
7.9 Нотолгоонд суурилсан сувилахуйн тусламж үйлчилгээг хөгжүүлэх
7.10 Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлж ажиллах талаар арга хэмжээ төлөвлөх , хэрэгжүүлэх
7.11 Сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтний цалин, урамшуулал, нийгмийн баталгааны асуудалд дүн шинжилгээ хийх, шийдвэрлүүлэх
7.12 Сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүдийн хүний нөөцийн бүрдэлт, хөгжлийг хангах асуудлыг байгууллагын түвшинд хариуцах, хамтран ажиллах
7.13 Сувилагч, эх баригчдын төгсөлтийн дараах болон тасралтгүй сургалтын хэрэгцээг тодорхойлж СЭШИА-тай хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх
7.14 Сувилагч, эх баригчдын мэргэжлийн болон боловсролын зэрэг ахиулах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх
7.15 Шинэ сувилагчийг чиглүүлэх, дасан зохицуулах хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх
7.16 Сувилахуйн тусламж үйлчилгээнд нэвтрүүлсэн шинэ технологийг дэмжих, нутагшуулах арга хэмжээг зохион байгуулах
7.17 Байгууллагын соёл болон Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага MNS7014:2023 стандартын хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг нэгдсэн удирдлагаар хангаж, сайжруулах санал шийдвэрийн төслийг байгууллагын захирал болон удирдлагын зөвлөлд тухай бүр танилцуулан шийдвэрлэж ажиллах

## НАЙМ. ХАЛДВАРЫН СЭРГИЙЛЭЛТ ХЯНАЛТЫН АЛБАНЫ АЖИЛЛАХ ЧИГ ҮҮРЭГ:

8.1 ХСХ-ын чиглэлээр мөрдөгдөж буй хууль, тогтоомжийн биелэлтийг хангуулж, хяналт тавих, байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон ЭТҮХХ, ХСХ-ын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх, шаардлагатай төсөв, санхүүжилтийг удирдлагын зөвлөлд танилцуулан төсөвт тусган шийдвэрлүүлэх
8.2 Байгууллагын түвшинд ЭТҮХХ-ын эрсдэлийг бууруулах, сэргийлэх, хянах арга хэмжээг зохион байгуулж хэрэгжүүлэх, нэгдсэн удирдлагаар хангах
8.3 ЭТҮХХ-ын тохиолдлыг лабораторийн шинжилгээгээр баталгаажуулах
8.4 Нянгийн тэсвэржилттэй уялдуулан нянгийн эсрэг эм, бэлдмэлийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх хөтөлбөр төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх
8.5 Байгууллагын ажиллагсад, үйлчлүүлэгч, тэдний гэр бүл, иргэдийг ЭТҮХХ-т өртөхөөс урьдчилан сэргийлэх, тохиолдлыг эрт илрүүлж тандалт судалгаа хийх, мэдээлэх, эрсдэлт хүчин зүйлийг тогтоох, хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэх, тандалт, судалгааны мэдээлэлд дүн шинжилгээ хийж тасаг нэгжүүдэд эргэн мэдээлэх
8.6 Эмнэлгийн багаж, хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариутгал, халдваргүйтгэлийн бодис, хувийн хамгаалах хувцас, хэрэгслийн тооцоо судалгааг гаргаж улсын бүртгэлд бүртгэгдсэн, эрүүл мэндийн байгууллагад хэрэглэх зориулалт бүхий чанарын шаардлага хангасан байх талаас нь удирдлагыг мэдээллээр хангаж шийдвэрлүүлэх

8.7 Эмнэлгийн байр орчинд хортон шавж, мэрэгч үүрлэх, тархахаас урьдчилан сэргийлж ахуйн шавж, мэрэгч устгал, халдваргүйжүүлэлтийг жилд нэг хоёр удаа, шавж мэрэгч үүрлэсэн тохиолдол бүрд мэргэжлийн байгууллагаар устгал хийлгэх
8.8 Эрүүл мэндийн ажилтнууд болон үйлчлүүлэгч нарыг эрүүл ахуйн шаардлага хангасан орчин нөхцөлд ажиллаж, тусламж үйлчилгээ авах нөхцлийг бүрдүүлэх чиглэлээр санал санаачилгатай ажиллах
8.9 Халдвараас сэргийлэх дэглэмийн зөрчил, алдаа дутагдлыг бүртгэж, арилгуулах арга хэмжээг тогтмол зохион байгуулах, ХСХ-ын чиглэлээр амжилт гаргасан тасаг, нэгж, эмнэлгийн ажилтнуудын үйл ажиллагаа, туршлагыг сурталчилж, урамшуулах
8.10 Эрүүл мэндийн ажилтнуудыг дархлаажуулах ажлыг тасралтгүй зохион байгуулж, дархлаажуулалтын нэгдсэн бүртгэл, судалгааны санг үүсгэх , үр дүнг удирдлагад тайлагнах
8.11 Цусаар дамжих халдвартай эрүүл мэндийн ажилтны эрүүл мэндийн байдалд жилд 2 удаа хяналт тавьж, вирусийн идэвхжилийг хянах, цусаар дамжих халдварын эрсдэлд өртсөн тохиолдлыг бүртгэж сэргийлэлтийн арга хэмжээг авч ажиллах
8.12 Эрүүл мэндийн байгууллагад дадлага хийж буй оюутан, дадлагажигч эмч дадлага хийх хугацаанд халдварт өртөхөөс сэргийлж байгууллагын дотоод журам зааврыг танилцуулж, мөрдүүлэх
8.13 Шинэ ажилтанг чиглүүлэх, дасан зохицох сургалтын хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх / гар угаах, халдваргүйжүүлэх мэдлэг, дадал олгох, хог хаягдлын ангилан ялгалт, багаж, материалын зөв хэрэглээ, хурц үзүүр иртэй багаж хэрэгсэлтэй зөв харьцах, халдвар авах эрсдэлт хүчин зүйлд өртөхөөс сэргийлэх, өртсөн үед халдвараас сэргийлэх, хувийн хамгаалах хувцас хэрэгслийг зөв хэрэглэх/
8.14 Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэргэжлийн эрсдэлт хүчин зүйлсийг судлан тогтоож, урьдчилан сэргийлэх арга хэмжээ, халдварт өртсөн байж болох тохиолдолд эрсдлийг үнэлэн, шаталсан арга хэмжээ хэрхэн авах талаарх мэдээллээр ажилтнуудыг бүрэн хангаж ажиллах
8.15 Эрүүл мэндийн ажилтнуудын халдварын сэргийлэлт, хяналтын талаарх мэдлэг, дадал, хандлагын үнэлгээ хийж, сургалтын хэрэгцээг тодорхойлох, ХСХ-ын мэдлэг, дадлыг сайжруулах сургалт, сурталчилгаа, аян, мэдээлэлийн ажлыг тасралтгүй зохион байгуулах, цус, биологийн шингэнтэй харьцдаг зорилтод бүлгийн ажилтнуудад үндсэн сургалтаас гадна нэмэлтээр ажлын байрны онцлогт тохирсон сургалтыг тогтмол зохион байгуулах

## ЕС. СТАТИСТИК МЭДЭЭЛЛИЙН АЛБАНЫ АЖИЛЛАХ ЧИГ ҮҮРЭГ:

**9.1** Эрүүл мэндийн статистикийн сар, улирал, жилийн мэдээ, тайланг батлагдсан маягтын дагуу тогтоосон хугацаанд хүлээн авч, нэгтгэх, боловсруулах, дүн шинжилгээ хийх, дээд шатны байгууллагуудад мэдээлэх, эргэн мэдээлэх, эмнэлгийн болон үйлчлэх хүрээний хүн амын эрүүл мэндийн үндсэн үзүүлэлтүүдийг сар, улирал, жилээр тооцон дүн шинжилгээ хийх, эмхэтгэх, эргэн мэдээлэх
**9.2** Эрүүл мэндийн статистик үзүүлэлтэд сар бүр дүн шинжилгээ хийж тасаг нэгжүүдийг мэдээллээр хангах, доголдсон статистик үзүүлэлтийг сайжруулах арга хэмжээг зохион байгуулах, нэгдсэн удирдлагаар хангах
**9.3** Эрүүл мэндийн статистик үзүүлэлтээр гарын авлага, боршур бэлтгэн улирал бүр тасаг нэгжүүдэд хүргүүлэх, статистик үзүүлэлтэд дүн шинжилгээ хийж сайжруулах чиглэлээр мэргэжил аргазүйгээр хангах
**9.4** Байгууллагын ЭМДЕГ-тай байгуулсан гэрээний хэрэгжилтийг хангаж ЭМДҮЗ-ийн 2022 оны 13 дугаар тогтоолын шалгуур үзүүлэлтэд сар бүр дүн шинжилгээ хийж тасаг, нэгжүүдийг мэдээллээр хангах
**9.5** Тасаг, нэгжийн мэдээ, мэдээллийг цуглуулах, бүртгэлийн болон тайлангийн маягтын хөтлөлтийн байдал, мэдээлэх ажилд хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгуулах, мэргэжлийн арга зүй, зөвлөмжөөр хангах, эрүүл мэндийн мэдээлэл, цахим эрүүл мэндийн бодлого шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хэрэгжилтэнд хяналт тавих
**9.6** Төлөвлөх, бодлого боловсруулах, шийдвэр гаргах түвшиний удирдлагууд болон мэдээлэл хэрэглэгчдээс шаардсан мэдээ, мэдээллийг ҮСГ, ЭМС-ын баталсанаас бусад маягт, аргачлалаар гаргаж өгөхөөс татгалзах

**9.7** Аймгийн ХЧА-ын үйл ажиллагааг тасралтгүй, дүрмийн дагуу зохион байгуулах

**9.8** Эрүүл мэндийн үзүүлэлтийг сүүлийн 10-аас доошгүй жилээр мэдээллийн сан үүсгэх, тогтмол баяжуулах, эх хүүхдийн эрүүл мэндийн бүртгэл, төрөлт, нас баралт, халдварт бус өвчлөлийн цахим мэдээний санг үүсгэх, архивлан хадгалах, жил бүр баяжилт, шинэчлэл хийх

**9.9** Мэдээллийн дэвшилтэд технологийг ашиглан эрүүл мэндийн статистикийн мэдээ, мэдээлэл бүртгэлийн болон тайлангийн маягтуудыг баримтжуулан цахим болон цаасан хэлбэрээр хадгалж архивлах

**9.10** Төсвийн ерөнхийлэн захирагчийн гүйцэтгэлийн гэрээ, түүний биелэлтийг захиргааны зөвлөл болон бүртгэл мэдээллийн ажилтантай хамтран байгууллагын хөгжлийн төлөв, үйл ажиллагаа, бодлогын бичиг баримттай уялдуулан гаргах, ЭМС-ын 346 тоот тушаалын биелэлтийг нэгтгэж тогтоосон хугацаанд илтгэх, хүргүүлэх, эдгээртэй холбоотой явцын үнэлгээг тогтмол хийх, дүгнэлт гаргах, эргэн мэдээлэх

**9.11** Hinfo-3, Ehealth програмын мэдээллийн алдаа, үнэн, зөв байдал, ЭМС-ын 611 тоот тушаал, ЭМДҮЗ-ийн 12 тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах

## АРАВ.ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛ МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙН АЛБАНЫ АЖИЛЛАХ ЧИГ ҮҮРЭГ

**10.1** Эрүүл мэндийн даатгал, мэдээлэл технологийн алба нь дотроо эрүүл мэндийн даатгал, мэдээлэл технологи гэсэн 2 нэгжтэй байна**.** Эрүүл мэндийн даатгалын хэсэг нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

10.1.1 Байгууллагын Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ худалдан авах” чиглэлээр байгуулсан гэрээний хэрэгжилтийг хангах үндсэн чиг үүргийг хүлээж гэрээний хэрэгжилттэй холбоотой үйл ажиллагааг байгууллагын хэмжээнд зохион байгуулах

10.1.2 Гэрээт 419 оношийн хамааралтай бүлгээр тусламж үйлчилгээ үзүүлж буй бүх үе шатанд өдөр тутам хяналт тавьж алдаа зөрчлийг тухай бүр засч залруулах

10.1.3 ЭМДҮЗ-ийн тогтоолуудын хэрэгжилт, гүйцэтгэлийн санхүүжилтийн орлого, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийн талаарх мэдээллийг эмч, мэргэжилтнүүдэд тогтмол танилцуулж алдаа зөрчлийг тухай бүр залруулах, дахин гарахаас сэргийлэх арга хэмжээг тогтмол зохион байгуулах, тайлагнах

10.1.4 Тусламж үйлчилгээний зардлын нэхэмжлэлийн дагуу нарийвчилсан хяналт хийхээр сонгогдсон түүврийн материалыг хугацаанд нь бүрэн хүргүүлж ажиллах

10.1.5 Гэрээнд заагаагүй тусламж үйлчилгээг шинээр үзүүлэх эсвэл жагсаалтад заагдсан тусламж үйлчилгээг үзүүлэх боломжгүй болсон хүсэлтийг эрүүл мэндийн тусламж үйлчилгээ худалдан авагчид тухай бүр мэдээлж холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх

10.1.6 Тусламж үйлчилгээний зардлыг тохиолдол бүрээр амжилттай нэхэмжлэх боломжийг хангахын зэрэгцээ гүйцэтгэлийн санхүүжилтийн орлогыг бүрэн бүрдүүлэхэд тулгамдаж буй асуудалд судалгаа дүгнэлт хийж удирдлагын зөвлөлийг мэдээллээр хангах, асуудлыг шийдвэрлүүлэх

10.1.7 Иргэн даатгуулагчид үзүүлж буй тусламж үйчилгээний чанарт өдөр бүр дүн шинжилгээ хийж тасаг нэгжүүдийг мэдээллээр хангах, эрсдлээс сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах

10.1.8 Эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой хууль тогтоомж, эрхзүйн акт болон даатгалаас санхүүжүүлэх тусламж үйлчилгээ, түүний төлбөрийн мэдээлэл зэргийг шинэчлэгдсэн тухай бүр иргэдэд ил тод мэдээлэх

10.1.9 Иргэн, даатгуулагчийн эрүүл мэндийн болон тусламж үйлчилгээний мэдээллийн нууцыг хадгалах чиглэлээр эмч, мэргэжилтнүүдэд сануулга, зөвлөмж хүргүүлж ажиллах

10.2 Мэдээлэл технологийн хэсэг нь дараах чиг үүргийг хэрэгжүүлж ажиллана.

10.2.1 Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэн иргэдэд ил тод, түргэн шуурхай, хүртээмжтэй, цаасгүй, чирэгдэлгүй хүргэж, цахим засаглалыг бодитой хэрэгжүүлэх арга хэмжээг тасралтгүй зохион байгуулах

10.2.2 Иргэдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх, мэдээлэл солилцох, өвчтөн шилжүүлэх ажлын хүрээнд Эрүүл мэндийн хөгжлийн төвтэй мэдээллийн аюулгүй байдал хангасан VPN сүлжээгээр холбох, уг үйлчилгээний төлбөрийг байгууллагын тухайн жилийн төсөвт суулган шийдвэрлэх

10.2.3 E-Health програм хангамжийн бүртгэл мэдээлэл, статистик тайланг сайжруулах, үнэн зөв алдаагүй гаргах зорилгоор системийн модулиудыг бүрэн хэтэлж хэвшүүлэх, эмч, эмнэлгийн мэргэжилтэн, удирдлагуудыг идэвхжүүлэх, хариуцлага хяналтын тогтолцоог бүрдүүлэх

10.2.4 Байгууллагын цахим мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангаж сүлжээ, серверүүдийн хэвийн үйл ажиллагааг тасралтгүй хангах

10.2.5 Лаборатори, дүрс оношилгооны тоног төхөөрөмжүүдийг албан ёсны лиценз, DICOM гарцтай худалдан авах ажиллагаанд тогтмолжуулах

10.2.6 Мэдээлэл технологийн үйл ажиллагаанд шаардлагатай санхүүжилтийн тооцоо судалгааг урьдчилан тооцоолж тухай жилийн төсөвт тусгаж шийдвэрлүүлэх /интернэтийн төлбөр, хорт кодын эсрэг программ худалдан авах зардал,шинэчлэх болон нэмэлтээр шаардлагатай мэдээлэл технологийн тоног төхөөрөмжин зардал, засвар үйлчилгээний зардал, вэб хуудасны домайн нэрийн төлбөр /

10.2.7 Мэдээллийн техник хэрэгслийн хэвийн үйл ажиллагааг тогтмол хангаж, засвар үйлчилгээг хариуцах

10.2.8 Мэдээлэл технологийн чиглэлээр байгууллагын хэмжээнд мөрдөж буй дүрэм журмын хэрэгжилтийг хангуулах

10.2.9 Цахим мэдээллийн аюулгүй байдлыг хангаж холбогдох арга хэмжээг тогтмол зохион байгуулах, хяналт тавих

## АРВАН НЭГ. СУРГАЛТ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ ИННОВАЦИЙН АЛБАНЫ АЖИЛЛАХ ЧИГ ҮҮРЭГ

**11.1** Сургалт, эрдэм шинжилгээ, хамтын ажиллагаатай холбоотой хууль тогтоомж , тушаал шийдвэрийн биелэлтийг хангуулж, хяналт тавьж ажиллах

**11.2** Тусламж үйлчилгээнд нэвтрүүлэхүйц оношилгоо эмчилгээний дэвшилтэт технологийн чиглэлээр сургалт, судалгаа, эрдэм шинжилгээ, хамтын ажиллагааг өргөжүүлэх төсөл хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх

**11.3** Олон улсын байгууллага, төрийн болон төрийн бус байгууллага, нийгэм холбоодтой хамтран ажиллах, харилцан туршлага солилцох үйл ажиллагааг зохион байгуулах

**11.4** Төгсөлтийн дараах сургалт эрхлэх зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн мэргэжлээр мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулах

**11.5** Эмнэлгийн мэргэжилтнүүдийн төгсөлтийн дараах болон тасралтгүй сургалтын хэрэгцээг тодорхойлж сургалтын хөтөлбөр , төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлэх, үр дүнг тайлагнах, төлөвлөх

**11.6** Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтанг судалгааны ур чадварт суралцахад дэмжлэг үзүүлж, эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхлэх боломж, нөхцөлийг хангах, байгууллагын хэмжээнд судалгаа болон эрдэм шинжилгээний ажлыг зохион байгуулах

**11.7** Өндөр хөгжилтэй орны ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг байгууллагад өөрийн ажилтанг сургах, мэргэшүүлэх, дэвшилтэт технологи нэвтрүүлэхэд мэргэжилтэн урьж хамтран ажиллах санал дэвшүүлж, шийдвэрлүүлэх.

**11.8** Гадаад дотоодын зээл тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх, хамтран ажиллах, үр дүнг тооцох

**11.9** БОЭТ-өөс эрхлэн гаргадаг “Анагаах увидас” эрдэм шинжилгээний сэтгүүлийг бэлтгэн нийтийн хүртээл болгох, өргөжүүлэх, сэтгүүлийн зөвлөлийн үйл ажиллагааг зохицуулах

**11.10** Эмнэлгийн ажилтнуудын гадаад хэлний мэдлэгийг дээшлүүлэх, сургах арга хэмжээг тасралтгүй зохион байгуулах

**11.11** Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох, нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр мэдээлэл, сургалт сурталчилгаа зохион байгуулах үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах, хэрэгжилтэд хяналт тавих

**11.12** Байгууллагын цахим хуудсанд хариуцсан чиг үүргийн талаарх мэдээ, мэдээлэлийг тогтмол тавьж ажилтан албан хаагч болон иргэн даатгуулагчийг мэдээллээр хангах

**ОРХОН АЙМАГ ДАХЬ БҮСИЙН ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН БҮТЭЦ**




## ДОЛОО. СТРАТЕГИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ХҮРЭХ ТҮВШИН

## ДОЛОО. СТРАТЕГИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ХҮРЭХ ТҮВШИН

| № | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь түвшин /2024/ | Хүрэх түвшин | | | | | Мэдээлэл цуглуулах давтамж |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 2025 | 2026 | 2027 | 2028 | 2029 | |
| 1 | Эмнэлэгт хоног болоогүй нас баралтын хувь (8-24 цагийн дотор) ЭО,ЧА | Хувь | 51.1 | 50.8 | 50.4 | 50 | 49.5 | 49 | Улирал бүр |
| 2 | Задлан шинжилгээний хувь ЭО,ЧА | Хувь | 50.4 | 53 | 55 | 57 | 59 | 61 | Улирал бүр |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | Үндсэн оношийн зөрүүний хувь ЭО,ЧА | Хувь | 11.1 | 10 | 9 | 8 | 7 | 6 | Улирал бүр |
| 4 | Эрчимт эмчилгээний орны фонд ашиглалтын хувь ЭО,ЧА | Хувь | 35.1 | 37 | 39 | 41 | 43 | 45 | Улирал бүр |
| 5 | Давтан хагалгааны хувь ЭО,ЧА | Хувь | 0.4 | 0.4 | 0.38 | 0.36 | 0.34 | 0.32 | Улирал бүр |
| 6 | Мэс заслын дараах хүндрэлийн хувь ЭО,ЧА | Хувь | 0.28 | 0.26 | 0.24 | 0.22 | 0.20 | 0.18 | Улирал бүр |
| 7 | Давтан хэвтэлтийн хувь ЭО,ЧА | Хувь | 0.17 | 0.15 | 0.13 | 0.12 | 0.10 | 0.08 | Улирал бүр |
| 8 | Нэг өвчтөнд ноогдох эмийн зардал СБА | тоо | 232,0 | 262,0 | 292,0 | 332,0 | 362,0 | 392,0 | Хагас жил |
| 9 | Байгууллагын өр, авлага СБА | Тоо | Өглөг - 5.1 тэр бум Авлага-2.7 тэрбум | Өр, авлагыг суурь түвшингээс жил бүр бууруулж ажиллана | | | | | Хагас жил |
| 10 | Эмчилгээ, оношилгоо, сувилахуйн тусламж үйлчилгээнд шинэ арга технологи нэвтрүүлсэн тоо, шинэ санаачлага ЧА | Тоо | 14 | 16 | 18 | 20 | 22 | 24 | Улирал бүр |
| 11 | Эмнэлгээр үйлчлүүлэх үедээ унаж, гэмтсэн тохиолдлын тоо ЧА | Тоо | 4 | 0 | 0 | 0 | 0 | 0 | Улирал бүр |
| 12 | Ходоодны шархлаа өвчний шалтгаант нас баралтын түвшин (0-74 насны 10 000 хүн амд) ЧА | Тоо | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | Улирал бүр |
| 13 | Даралт ихсэх өвчний шалтгаант нас баралтын түвшин (0-74 насны 10 000 хүн амд) ЧА | Тоо | 7 | 6 | 5 | 4 | 3 | 2 | Улирал бүр |
| 14 | Гуурсан хоолойн багтраа өвчний шалтгаант нас баралтын түвшин (0-44 насны 10 000 хүн амд) | Тоо | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | Улирал бүр |
| 15 | Мухар олгойн шалтгаант нас баралтын түвшин (0-74 насны 10 000 хүн амд) | Тоо | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | Улирал бүр |
| 16 | Цөсний чулуу, цөсний үрэвслийн шалтгаант нас баралтын түвшин (0-74 насны 10 000 хүн амд) | Тоо | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | Улирал бүр |
| 17 | Тархинд цус харвалтын нас баралтын түвшин (0-74 насны 10 000 хүн амд) | Тоо | 9 | 8 | 7 | 6 | 5 | 4 | Улирал бүр |
| 18 | Зүрхний шигдээсийн нас баралтын түвшин (0-74 насны 10 000 хүн амд) | Тоо | 2 | 2 | 2 | 1 | 1 | 0 | Улирал бүр |
| 19 | Амбулаторийн идэвхитэй хяналтын хувь | Хувь | 8.4 | 10 | 12 | 14 | 15 | 17 | Улирал бүр |
| 20 | 1000 амьд төрөлтөд ногдох нярайн эндэгдлийн түвшин | | 7.4 | 7.4 | 7.3 | 7.2 | 7.1 | 7.0 | Улирал бүр |
| 21 | 0-1 насны нялхсын эндэгдэл | | 8.9 | 8.9 | 8.8 | 8.7 | 8.6 | 8.5 | Улирал бүр |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 22 | 1000 амьд төрөлтөд эхийн эндэгдлийн харьцаа | Прос анити милл | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | Улирал бүр |
| 23 | Зүрх судасны өвчлөлөөс шалтгаалсан нас баралтын түвшин, 10000 хүн амд | Проде цимил л | 30 | 28 | 26 | 24 | 22 | 20 | Улирал бүр |
| 24 | Хорт хавдраас шалтгаалсан нас баралтын түвшин, 10000 хүн амд | Проде цимил л | 14 | 13 | 12 | 11 | 10 | 9 | Улирал бүр |
| 25 | Эмч, сувилагчийн харьцаа | Тоо | 1:1.3 | 1:1.3 | 1:1.2 | 1:1.2 | 1:1.1 | 1:1 | Хагас жил тутам |
| 26 | Нийгмийн дэмжлэгт хамрагдсан эрүүл мэндийн ажилтан | хувь | 9,7% | 10.6 | 11.5 | 12.5 | 13.4 | 14.3 | Хагас жил тутам |
| 27 | Төгсөлтийн дараах сургалтад хамрагдсан эмч, сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн | хувь | 13.6 | 15.1 | 16.4 | 17.8 | 19.1 | 20.5 | Хагас жил тутам |
| 28 | Мэргэжлийн зэрэгтэй эмнэлгийн мэргэжилтэн | Хувь | 37.7 | 38.8 | 40.1 | 41.4 | 42.6 | 43.8 | Хагас жил тутам |

## НАЙМ. СТРАТЕГИЙН ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭ

**Зорилго:** Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний талаар Засгийн газраас баримтлах бодлогын үр дүн, үр нөлөөг сайжруулж, хариуцлагыг бэхжүүлэх, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлэх, эмнэлгийн болон нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх .

**Үр дүн:** Хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлж, байгууллагын үйл ажиллагааны гүйцэтгэл сайжирсан, үр нөлөөний үнэлгээ хийгдсэн байна.

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

8.1. Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээ үнэлгээг байгууллагын дотоод хяналтын ажилтан нь жилд 1 удаа хийж дүнг удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулна.

8.2. Удирдлагын зөвлөл нь стратегийн хэрэгжилтийн үнэлгээнд дүн шинжилгээ хийж зөвлөмжид тусгагдсан ажлыг эрчимжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж, шаардагдах зардлыг төсөвт тусгана.

--- oOo ---

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 дугаар тушаалын
2 дугаар хавсралт

*Төлөвлөгөөг хянасан:* ***Төсвийн Ерөнхийлөн захирагч***

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД ........................ / Ж.ЧИНБҮРЭН /
*(албан тушаал)* *(гарын үсэг)*
*(огноо)*
*Тэмдэг* ..............................

*Төлөвлөгөө баталсан:* ***Төсвийн Шууд захирагч***

БҮСИЙН ОНОШИЛГОО ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ЗАХИРАЛ

*(албан тушаал)* ...................... /Ц.НАРАН-ЭРДЭНЭ /
*(гарын үсэг)*

*(огноо)*
*Тэмдэг* ..............................

# ОРХОН АЙМГИЙН БҮСИЙН ОНОШИЛГОО ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ (2025-2029 ОН )

| | Бодлогын баримт бичигт тусгагдсан үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт | Стратеги /арга зам/ | Шалгуур үзүүлэлт | 2025 он | 2026 он | 2027 он | 2028 он | 2029 он | Суурь түвшин | Зорилтот түвшин | Санхүүгийн эх үүсвэр |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Ерөнхий чиг үүргийн нэр:** Бүс нутгийн хүн амд лавлагаа шатлалын тусламж үйлчилгээ үзүүлэх, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, эрэлт хэрэгцээг судлах, анагаах ухааны судалгаа шинжилгээний ажил эрхлэх | | | | | | | | | | | |
| **Үндсэн чиг үүргийн нэр:** Байгууллагын үйл ажиллагааны хөгжлийг дэмжих, удирдлага зохион байгуулалтыг боловсронгуй болгох | | | | | | | | | | | |
| | **Зорилт 1.** Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд чанарын стандарт, чанар | **Арга хэмжээ 1.** Чанарын ISO 9001-2015 стандартыг нэвтрүүлэх | Баталгаажсан чанарын гэрчилгээ | - | 30% | 70% | 100% | - | - | 100% | 50сая |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | сайжруулах арга хэрэгслийг тасралтгүй ашиглах тогтолцоог бэхжүүлнэ. | **Арга хэмжээ 2.** Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах хөтөлбөр батлуулж хэрэгжилтийг хангах | Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь | 80% | 85% | 90% | 95% | 100 % | 70% | 100% | - |
| | **Зорилт 2.** Халдварын сэргийлэлт хяналтын тогтолцоог бэхжүүлж ЭТҮХХ-ын эрсдлийг бууруулж ажиллана. | **Арга хэмжээ1.** Халдварын сэргийлэлт, хяналтад бичил амь судлалын лабораторийн гүйцэтгэх үүргийг өргөжүүлнэ. | Арга хэмжээний тайлан | 80% | 85% | 90% | 95% | 100 % | 70% | 100% | - |
| | | **Арга хэмжээ 2.** Нянгийн эсрэг эмийн хэрэглээг төлөвшүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ | Байгууллагын антибиограмм ашиглалтын хувь | 65% | 70% | 75% | 80% | 85% | 60% | 85% | - |
| | | **Арга хэмжээ3.** ЭТҮХХ-аас сэргийлэх арга хэмжээний тогтолцоог бэхжүүлнэ. | ЭТҮХХ-ын тохиолдлын тоо | 8 | 7 | 6 | 5 | 4 | 8 | 3 | - |
| | **Зорилт 3.** Эмнэлгийн тусламж үйлчилгээнд нэн шаардлагатай тоног төхөөрөмж, эм эмнэлгийн хэрэгслээр тасарлтгүй хангана. | **Арга хэмжээ 1.** Эрчимт эмчилгээ мэдээгүйжүүлэг, эмгэг судлал, пренатал оношилгоо, мэс заслын тусламж үйлчилгээний чиглэлээр нэн шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана | Тоног төхөөрөмжийн хангалтын хувь | 65% | 70% | 75% | 80% | 85% | 60% | 85% | 1.8 тэрбум |
| | **Зорилт 4.** Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага MNS 7014:2023 стандартын хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллана. | **Арга хэмжээ 1.** Үйлчлүүлэгчийг дэмжих алба болон орон тооны бус зөвлөл, нэгжийг томилон ажиллуулна | Томилогдсон алба, нэгж | 70% | 85% | 100% | - | - | 0% | 90% | - |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | **Арга хэмжээ 2.** Байгууллагын болон тасаг нэгжүүдийн гадна хаягжилт, эмнэлгийн гадна талбайн маршрут, орох гарах, гарц чиглэл, эмнэлгийн эдэлбэр газарт байгууламж хоорондын бүх явган хүний зам, тээврийн хэрэгслийн замын мэдээлэл, яаралтай тусламжийн тасгийн байршил заасан тэмдэг, яаралтай тусламжийн автомашины тэмдэглэгээ зэргийг стандартад нийцүүлэн зохион байгуулна | Стандартын хэрэгжилтийн хувь | 60% | 70% | 80% | 90% | 100 % | 50% | 100% | 250 сая |
| | | **Арга хэмжээ 3.** Эмнэлгийн амбулаторийн үзлэг, шинжилгээний дугаар авах, цаг товлох үйлчилгээ, дотоод хаягжилт, хэвтүүлэн эмчлэх болон өдрийн эмчилгээний өрөөнд дуудагдах дуудлагын тогтолцоог стандартад нийцүүлэн зохион байгуулна. | Стандартын хэрэгжилтийн хувь | 80% | 90% | 100% | - | - | 70% | 100% | 75сая |
| | **Зорилт 5.** Бүсийн түвшинд эрдэм шинжилгээ, судалгааны ажлын тэргүүлэх чиглэлийг тогтоож хүн амын эрүүл мэндийн байдал, тусламж үйлчилгээний эрэлт | **Арга хэмжээ 1.** Хүн амын өвчлөл нас баралтын тэргүүлэх шалтгаанд нөлөөлж буй хүчин зүйлс, тэдгээрийг бууруулах чиглэлээр Бүс нутгийн | Судалгааны тоо, практикт нэвтрүүлсэн үр дүн | 16 | 20 | 25 | 30 | 35 | 16 | 35 | 10сая |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгцээг судлах, нотолгоонд суурилсан анагаах ухааны хөгжүүлэх | хэмжээнд эрдэм шинжилгээ судалгааны ажлыг зохион байгуулан ажиллана | | | | | | | | | |
| | **Зорилт 6.** Гадаад дотоодын хамтын ажиллагааг салбарын бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулан хөгжүүлэх, гадаадын хөрөнгө оруулалт, зээл, тусламжийг татан төвлөрүүлэх, мэргэжилтэн сургах арга хэмжээг хэрэгжүүлнэ. | Хэрэгжүүлсэн төсөл, гадаадад мэргэжил дээшлүүлсэн мэргэжилтний тоо | 24 | 27 | 30 | 33 | 36 | 40 | 24 | 40 | - |
| | **Зорилт 7.** Байгууллагын цахим хуудасны хөгжүүлэлтийг өргөжүүлж байгууллагын ил тод байдлыг хангана. | Цахим хуудасны хөгжүүлэлт | 70% | 90% | 100% | - | - | - | Нийт 9000 дагагч | 15-20 хувиар өсгөнө | 10сая |
| **Ерөнхий чиг үүргийн нэр:** Эмнэлгийн тусламж үйлчилгээний стратеги | | | | | | | | | | | |
| **Үндсэн чиг үүргийн нэр:** Үйлчлэх хүрээний болон харьяалах нутаг дэвсгэрийн хүн амд эмнэлгийн тусламж үйлчилгээг чанартай хүртээмжтэй хүргэх, эмчилгээ оношилгоонд шинэ дэвшилтэт технологи нэвтрүүлэх нутагшуулах, хамтын ажиллагааг өргөжүүлж мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллах | | | | | | | | | | | |
| | **Зорилт 1.** Хүн амын өвчлөл, нас баралтын тэргүүлэх шалтгааныг бууруулах, төвлөрлийг сааруулах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлнэ. | **Арга хэмжээ:1**<br>- Өндөр эрсдэлт бүлгийг эрт илрүүлэг<br>- Өвчлөл, нас баралтын буурсан хувь | 1. Төлөвлөгөө<br>2. Хамтын ажиллагаа | 30% | 60% | 80% | 90% | 100 % | 30% | 100% | 30сая |
| | | **Арга хэмжээ:2** Пренатал оношилгооны төв байгуулна | 1. Хүний нөөц<br>2. Тоног төхөөрөмж<br>3. Хамтын ажиллагаа | 60% | 70% | 80% | 90% | 100 % | 50% | 100% | 669сая |
| | | **Арга хэмжээ:3** Зүрхний төвийг байгуулна | 1. Эрхзүйн баримт бичиг | 50% | 70% | 80% | 90% | 100 % | 0% | 100% | 8.2 тэрбум |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 2. Хүний нөөц<br>3. Тоног төхөөрөмж<br>4. Хамтын ажиллагаа | | | | | | | | |
| | | **Арга хэмжээ:4** Яаралтай тусламжийн төвийг байгуулна | 1. Хүний нөөц<br>2. Тоног төхөөрөмж<br>3. Хамтын ажиллагаа | 50% | 70% | 80% | 90% | 100 % | 0% | 100% | 48тэрбум |
| | **Зорилт 2.** Мэс заслын тусламж үйлчилгээг хөгжүүлж шинэ дэвшилтэт технологийг нутагшуулна | **Арга хэмжээ:1** Хавдрын мэс заслын тусламж үйлчилгээг нэвтрүүлж нутагшуулна. /Элэгний судас боох болон түлэх, Элэгний хавдар тайрах/ | 1. Нэр төрөл<br>2. Мэс засал хийсэн тоо | 1 – 4<br>2- 20 | 1 – 5<br>2- 30 | 1 – 6<br>2- 40 | 1 – 6<br>2- 50 | 1 – 6<br>2- 60 | 30% | 100% | 1.2 тэрбум |
| | | **Арга хэмжээ:2** Тархины судасны цүлхэнд хавчаар тавих, мөчдийн бүх төрлийн судас, мэдрэл шөрмөс залгах, шилжүүлэн суулгах, хүзүү нуруу нугасны мэдрэлийн дарагдал чөлөөлөх мэс заслуудыг нэвтрүүлэн нутагшуулна. | 1. Нэр төрөл<br>2. Мэс засал хийсэн тоо<br>3. Тоног төхөөрөмжийн хангалт | 1 – 4<br>2- 10 | 1 – 5<br>2- 20 | 1 – 6<br>2- 30 | 1 – 6<br>2- 40 | 1 – 6<br>2- 50 | 30% | 100% | 840сая |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Арга хэмжээ: 3 Цээжний хөндийн мэс заслын тусламж үйлчилгээг өргөжүүлнэ | 1,Нэр төрөл<br>2,Мэс засал хийсэн тоо | 0 | 1 – 4<br>2- 10 | 1 – 5<br>2- 20 | 1 – 6<br>2- 30 | 1 – 7<br>2- 35 | 0 | 100% | 500сая |
| | **Зорилт3.** Орон нутагт эмчлэх, оношлох боломжгүй тусламж үйлчилгээг нутагшуулж шинэ дэвшилтэт технологийг нэвтрүүлнэ | **Арга хэмжээ 1.** Зүрхний хэм алдагдлын электрофизиологийн оношилгоо, эмчилгээг нэвтрүүлж нутагшуулна. (Аблаци эмчилгээ) | 1. Нэр төрөл<br>2. Мэс засал хийсэн тоо | - | 1-1<br>2-3 | 1-2<br>2-10 | 1-3<br>2-15 | 1-4<br>2-20 | 0% | 100% | - |
| | | **Арга хэмжээ 2.** Тархины судасны цүлхэн, эмгэг сүлжээрлийг судсан дотуурх бичил койлоор бөглөх аргыг нэвтрүүлж нутагшуулна | 1. Мэс заслын тоо | 2 | 5 | 10 | 15 | 20 | 1 | 100% | 20сая |
| | | **Арга хэмжээ 3.** Хэвлийн дурангаар бөөр авах, давсагны хавдар авах мэс засал, бөөр тайрах мэс засал, нарийн гэдсээр хиймэл давсаг хийх мэс засал эмчилгээг нэвтрүүлж нутагшуулна | 1. Нэр төрөл<br>2. Мэс засал хийсэн тоо<br>3. Тоног төхөөрөмжийн хангалт | 1-1<br>2-2<br>3-1 | 1-2<br>2-10<br>3-2 | 1-3<br>2-15<br>3-3 | 1-4<br>2-20<br>3-4 | 1-5<br>2-25<br>3-5 | 0 | 1-15<br>2-72<br>3-15 | - |
| | | **Арга хэмжээ 4.** Хэвлийн дурангаар умайг бүхэлд нь аарцгийн тунгалагын булчирхайн хамт авах өргөтгөсөн хагалгааг | 1. Мэс заслын тоо<br>2. Тоног төхөөрөмж | - | 1-2<br>2-1 | 1-5<br>2-2 | 1-10 | 1-15 | 0 | | 60сая |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | нэвтрүүлж нутагшуулна. | ийн хангалт | | | | | | | | |
| **Ерөнхий чиг үүрэг-3:** Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний стратеги | | | | | | | | | | | |
| **Үндсэн чиг үүрэг:** Гамшгийн болон нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэх | | | | | | | | | | | |
| | **Зорилт 1.** Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ | **Арга хэмжээ 1** Нийгмийн эрүүл мэндийг дэмжих орон тооны бус алба, нэгжийг байгуулна. | НЭМ-ийг дэмжих алба | 50% | 100% | - | - | - | 0% | 100% | |
| | | **Арга хэмжээ** 2 Өндөр эрсдэлт бүлгийн эрт илрүүлэг хийх тогтолцоог бэхжүүлнэ | Хамрагдалтын хувь | 31% | 51% | 61% | 81% | 100 % | 21% | 100% | |
| | | **Арга хэмжээ 3** Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, гамшиг, онцгой байдлын үед урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэх чадавхыг бэхжүүлнэ. | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 70% | 80% | 90% | 100% | - | 70% | 100% | |
| **Ерөнхий чиг үүрэг -4 :** Хүний нөөцийн хөгжлийн стратеги | | | | | | | | | | | |
| **Үндсэн чиг үүрэг:** Эрүүл мэндийн ажилтны ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх боломжийг нэмэгдүүлж, нийгмийн баталгааг сайжруулан, тэдний эрүүл аюулгүй тав тухтай ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлэх | | | | | | | | | | | |
| | **ҮЧҮ-4.1:** Эрүүл мэндийн ажилтны ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх боломжийг нэмэгдүүлж, нийгмийн баталгаар сайжруулан, тэдний эрүүл аюулгүй тав тухтай ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлэх | Байгууллагын хүний нөөцийг хөгжүүлэх дэд хөтөлбөр батлуулж хэрэгжүүлэх | Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь | 80% | 90% | 100% | - | - | 70% | 100 | |
| | | Эмнэлгийн мэргэжилтнийг үндсэн болон төрөлжсөн сургалтад хамруулж мэргэшүүлэх, чадавхжуулах | Мэргэшсэн мэргэжилтний эзлэх хувь | 15.1 | 16.4 | 17.8 | 19.1 | 20.5 | 13.6 | 20.5 | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн болон боловсролын зэрэг дэвийг ахиулах арга хэмжээг дэмжин зохион байгуулах | Боловсролын зэрэгтэй мэргэжилтний хувь | 38.8 | 40.1 | 41.4 | 42.6 | 43.8 | 37.7 | 43.8 | |
| | | Эрүүл мэндийн ажилтны нийгмийн баталгааг сайжруулан, урамшууллын тогтолцоог боловсронгуй болгох, тэдний эрүүл аюулгүй тав тухтай ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлэх | Нийгмийн дэмжлэгт хамрагдсан эрүүл мэндийн ажилтаны хувь | 10.6 | 11.5 | 12.5 | 13.4 | 14.3 | 9.7 | 14.3 | |
| | | Төгсөлтийн дараах сургалт эрхлэх байгууллагын үйл ажиллагаар өргөжүүлэх | 1. Сургалтын чиглэл төрөл<br>2. Төгсөгчийн тоо | 1-3<br>2-10 | 1-4<br>2-10 | 1-4<br>2-15 | 1-4<br>2-15 | 1-4<br>2-15 | 1-3<br>2-24 | 1-4<br>2-65 | |
| **Ерөнхий чиг үүрэг -5 :** Мэдээллийн технологийн хөгжлийн стратеги | | | | | | | | | | | |
| **Үндсэн чиг үүрэг:** Эрүүл мэндийн салбарт хийгдэж буй цахим шинэчлэлтийг байгууллагын үйл ажиллагаанд тухай бүр нэвтрүүлж сүлжээ, сервер, программын цахим аюулгүй байдлыг хангах, хөгжүүлэх технологийн шинэчлэл хийх | | | | | | | | | | | |
| | **ҮЧҮ-5.1:** Эрүүл мэндийн салбарт хийгдэж буй цахим шинэчлэлтийг байгууллагын үйл ажиллагаанд тухай бүр нэвтрүүлж сүлжээ, сервер, программын цахим аюулгүй байдлыг хангах, хөгжүүлэх технологийн шинэчлэл хийх | **Арга хэмжээ 1** Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээнд хамрагдаж зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах | Зөвлөмжийн хэрэгжилтийн хувь | | 50% | 70% | 100% | - | 0% | 100 % | 15сая |
| | | **Арга хэмжээ 2** Байгууллагын дотоод сүлжээ, серверийн хүчин чадлыг сайжруулж интернэтийн хурд, комьпютерийн хангалтыг нэмэгдүүлэх | - Интернет хурд<br>- Мэдээлэл, аюулгүй байдал | 70% | 100 % | - | - | - | 60/20мб | 200мб | 80сая |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Ерөнхий чиг үүрэг-6:** Байгууллагын дэд бүтцийг хөгжүүлэх стратеги | | | | | | | | | | | | |
| **Үндсэн чиг үүрэг:** Ажлын байрны болон үйлчлүүлэгчийн эрүүл аюулгүй орчин нөхцлийг бүрдүүлэх | | | | | | | | | | | | |
| | **ҮЧҮ-6.1:** Байгууллагын барилга байгууламж, дэд бүтцийг хөгжүүлж сайжруулан стандарт, чанарын шаардлага хангасан үйлчилгээ үзүүлэх орчныг бүрдүүлнэ. | Шаардлагатай тасаг нэгжүүдэд дээврийн болон барилга их засвар хийх, агааржуулалтын шугам хоолойг шинэчлэх, суурилуулах гадна инженерийн шугам сүлжээ, цахилгаан кабель шугамыг шинэчлэх | Зураг төсөв | Дүрс онош илгоо, ХАНТ | Мэс засал, Гэмтэл | Амбулатори, Төрөх | - | - | - | 100% | 1.5 тэрбум |
| | | Эмгэг судлал, Төрөх тасаг, Халдварт, сүрьеэ сэтгэцийн тасгуудад их засварыг үе шаттай зохион байгуулах | Их засварын гүйцэтгэлийн хувь | Төрөх тасаг | Халдварт сүрьеэ, Эмгэг судлал | Сэтгэц | - | - | - | 100% | 3.1 тэрбум |